

"БУЛГАН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛТ"-ИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Бодлогын зорилго, зорилт арга хэмжээ	Төсөв /сая.төг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь	Тайлбар (хүрээгүй шалтгаан нөхцөлийн тайлбар/)	бол
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин				
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
<p><b>НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ. Орон нутгийн онцлог, хүн амын амьдралын хэв маяг, хэрэгцээ шаардлагад тохирсон боловсрол, соёл, спорт, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн салбарын үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулана.</b></p>												
<p><b>Зорилт 1.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлэх</b></p>												
1.1.1	Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахуйд суралцах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцсан байна.	50.0	199.4	Сургалтын орчин сайжирсан сургуулийн тоо, Шинэ ирээдүй дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хувь	2020	17 сургуульд анги танхим, лаборатори тохижуулах ажил хийгдсэн.	2022	5 сургуулийн сургалтын орчин сайжруулах, Шинэ ирээдүй дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 80-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна.	Байгалийн ухааны сургалтын орчныг сайжруулахад "Тогтвортой хөгжлийн боловсрол 2" төслөөс 60.0 сая, орон нутгийн төсвөөс 20.0 сая, нийт 80.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Төслийн хүрээнд Булган сумын Эрдмийн Өргөө цогцолбор сургуульд "Эко номын сан", Могод суманд "Цахим танхим", Хишиг-Өндөр сум "Ногоон оффис", Хялганат тосгон "Эко зуслан" төслүүдийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд сургалтын таатай, ногоон орчин бүрдэж, эх дэлхийгээ хайрлах, усыг хэмнэх, зөв зохиистой хэрэглэх байгалийн ухааны боловсролыг олгож байгаа төдийгүй, СӨБ-ын бүх байгууллагууд хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, сав хийх, сургалт үйл ажиллагаанд ашиглах зэргээр хүүхдүүдэд хүрээлэн буй орчинтойгоо зөв харилцах дадал хэвшил олгож байна. Булган сумын 3-р сургууль математикийн кабинетийн 10.0 сая төгрөгийн хэрэглэгдэхүүн, 13.0 сая төгрөгийн ухаалаг дэлгэц, Рашаант сумын сургууль математикийн кабинетийн 10.0 сая төгрөгийн хэрэглэгдэхүүн, МУБИС-ийн байгалийн ухааны тэнхимтэй хамтарсан төслийн хүрээнд физикийн хичээлийн 6.0 сая төгрөгийн хэрэглэгдэхүүнтэй тус тус боллоо. "Шинэ ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд лектор болон ментор багш нар, төрийн бэлэн төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 80 гаруй сургалт, нөлөөллийн арга хэмжээ, гүйцэтгэл оношлох үнэлгээ зэрэгт давхардсан тоогоор 17974 хүүхдийг хамрууллаа. Боловсролын үнэлгээний төвтэй хамтран II-XII ангийн сурагчдыг оношлох үнэлгээг судлагдахуун бүрээр хийж, мэргэжлийн 68 багштай баг байгуулан зөвлөмж боловсруулж, бүх сургуульд хүргүүлсэн. Бага ангийн монгол хэлний үнэлгээ 7.7 хувь, дунд ангийн монгол хэлний үнэлгээ 8.0 хувь, ахлах ангийн үнэлгээ 6.4 хувиар тус тус ахисан бол 12 дугаар ангийн сурагчдын сургуульд суурилсан үнэлгээгээр нийгмийн ухааны хичээлүүдэд /монгол хэл, нийгмийн ухаан/ 1-3 хувь ахиц гарсан байна. Хүүхэд хамгааллын чиглэлээр 40 гаруй төрлийн сургалт, үйл ажиллагаанд 8-12 дугаар ангийн 4000 гаруй хүүхэд, багш нарыг оролцуулсан нь өмнөх оноос 85.0 хувиар ахисан, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа өмнөх оноос 16.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. "Шинэ Ирээдүй" хөтөлбөрийн үр дүнд Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 504.8 буюу өмнөх оноос 23.5 хувиар өссөн. Хөтөлбөрийн хүрээнд 80.4 сая төгрөгийг зарцуулж, хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 85.5 хувьтай байна.	100		
1.1.2	Элсэлтийн ерөнхий шалгалтын аймгийн дундаж оноо улсын дундаж онооноос 5-аас доошгүй хувиар нэмэгдсэн байна.	-	-	Элсэлтийн ерөнхий шалгалтын онооны ахисан хувь	2020	508.2	2022	Элсэлтийн ерөнхий шалгалтын оноог 1 хувиар ахиулсан байна.	"Шинэ Ирээдүй" хөтөлбөрийн үр дүнд Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 507.8 байна. Аймгийн дундаж үзүүлэлтээс 17 хувиар нэмэгдсэн байна.	50		
1.1.3	Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдийн "Насан туршийн боловсрол"-ыг дэмжих боломж бүрдсэн байна.	10.0	356.8	Шинээр нэвтрүүлсэн цахим платформын тоо Насан туршын боловсролын хамрагдалтын нийт хүн амд эзлэх хувь	2020	Динамик сайтгүй, нийт хүн амын 20 хувьд насан туршийн боловсрол олгож байна.	2022	Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулсан байна. Насан туршын боловсролын хамрагдалтыг 25 хувьд хүргэнэ.	Боловсролын салбарт мэдээллийн технологи, цахим платформ, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэвтрүүлж, багш ажилчид суралцагчдыг цахим орчинд ажиллах, суралцах нөхцөлийг бүрдүүлэхээр ерөнхий боловсролын 11 сургууль болон Боловсрол, шинжлэх ухааны газрын "Багшийн хөгжлийн төв"-д 157.0 сая төгрөгөөр ухаалаг дэлгэц, 3 дугаар сургуульд "Студийн тоног төхөөрөмж"-д 57.0 сая төгрөг, Бүгд найрамдах Солонгос улсын Дэчон хотын Боловсролын газраас Булган сумын 1 дүгээр сургуульд 142.8 сая төгрөгийн "Smart class" цахим кабинетийг шинээр тохижуулан нийт 356.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Боловсролын үнэлгээний төвтэй хамтран нээлттэй даалгаврын сангийн системд энэ онд ерөнхий боловсролын 22 сургууль бага боловсролд 1750, суурь боловсролд 3300, бүрэн дунд боловсролд 2000 даалгавар боловсруулан шивж оруулахаар сан бүрдүүлэн ажиллаж байна. "Ээлжит хичээлийн цахим контентын сан"-д 282 цагийн хичээл байршууллаа. БШУГ-ын албан ёсны вэб сайтад багш нарын цахим хичээл байршуулах ажил хийгдэж байгаа ба боловсролын динамик сайт, цахим платформтой холбож өгсөн. ЕБС-чуд аську.mn болон үнэлгээний даалгаврын нэгдсэн сангийн iteambank.ees.mn цахим системийг ашиглах гэрээг хийж, Могод, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль "Амжилт-2.0" системийг нэвтрүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд багш нарын цахим орчин нөхцөлд ажиллах боломж, чадвар 12.0 хувиар, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж 23.0 хувиар ахисан амжилттай байна.	92		
1.1.4	Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулж, харилцан туршлага солилцох боломж олгон, нийгмийн асуудал нь үе шаттай шийдвэрлэгдсэн байна.	25.0	114.4	"Шинэ багш" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	-	2022	"Шинэ багш" дэд хөтөлбөр 80-аас доошгүй хувийн хэрэгжилттэй байна.	"Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилтын 22 арга хэмжээг хэрэгжүүлж, "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг хэрэгжүүлэн зорилтот 4 модулийн 223 төрлийн цахим болон танхимын сургалт, уулзалтанд давхардсан тоогоор 52284 багш, удирдах ажилтныг хамруулан нийт 114.4 сая төгрөгийг зарцууллаа. Тухайлбал: "Багш солилцоо" хөтөлбөрөөр 10 байгууллагын 16 хүн арга зүй, туршлага солилцож, 195 судалгаат хичээлийг зохион байгуулсан. Багшлах хүний нөөц, нөхөн хангалтыг сайжруулахаар "БАТЛАМЖ" шалгалтыг зохион байгуулж багш нарын ахиц, амжилтын судалгаа өмнөх оноос 4.0 хувиар ахисан ба 68.0 хувь нь 3-6 дугаар түвшний мэдлэгтэй байна. Судлагдахуун тус бүрийн мэргэжил дээшлүүлэх сургалтуудад 19 чиглэлээр 2272 багш, удирдах ажилтан хамруулж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд нийт багш нарын 80.0 хувь нь "Багш хөгжлийн төлөвлөгөө"-тэй ажиллаж, "Зөвлөх" зэрэгтэй багш 3-аар нэмэгдэж 12 болж өмнөх оноос 38.0 хувиар, "Тэргүүлэх" зэрэгтэй багш 125 буюу 52.0 хувиар, магистр зэрэгтэй багш 74 буюу 9.2 хувиар тус тус өссөн байна. Үүний үр дүнд улсын илтгэлийн уралдаанд 6 дугаар байр, Нийгмийн тухай мэдлэгийн улсын эссэ бичлэгийн уралдаанд тэргүүн байр эзэлж, улсын төрөлжсөн олимпиадаас 3, 6, 13 дугаар байранд шалгарсан амжилт үзүүлээд байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 84.5 хувьтай байна. 20 багшийг дотоод нөөц бололцоонд тулгуурлан амьдрах орчноор ханган ажиллаж байна. 2023 онд 3 суманд багш ажилчдыг дэмжсэн орон сууцны барилгын ажлыг эхлүүлэхээр төсөвт батлуулж чадсан.	100		

1.1.5	Багш, сурагчдын сурч, хөгжих орчин сайжирч, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалт үе шаттайгаар хийгдэн боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэн, "Хүүхдэд ээлтэй" сургалтын орчин нөхцөл бүрдсэн байна.	10,000.0	5,408.8	Боловсролын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын тоо	2020	Сургуулийн 2 шинэ барилгын өргөтгөл, 5 их засвар, цацарлэгийн 7 шинэ барилгын өргөтгөл, 4 их засвар, дотуур байрны 4 шинэ барилга, 2 их засвар, сургуулийн 3 спорт заалыг шинээр барих шаардлагатай.	2022	5 сургуулийн сургалтын орчин сайжирсан байна	Цэцэрлэг, сургуулийн тоног төхөөрөмж, тоглоом, тохижилтын ажил өмнөх оноос 52.4 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Ерөнхий боловсролын сургуулийн нийт хөрөнгө оруулалтын 44.0 хувь нь улсын төсвөөс, 15.5 хувь нь орон нутгийн төсвөөс, 3.5 хувь нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, 14.2 хувь нь байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрөөс, 6.3 хувь нь иргэдийн хандив тусламжаар, 3.7 хувь нь аж ахуйн нэгжийн хандиваас бүрдсэн байна. Мөн 20 сургуульд математикийн кабинет байгуулахад 200.0 сая төгрөг, Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүдийн ажлын байрны тоног төхөөрөмжийг сайжруулахад 20.0 сая төгрөг, нийт 220.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэлээ. Цацарлэгийн өргөтгөл, шинэ барилга өмнөх оноос 36.0 хувиар, их засвар 37.7 хувиар буурч, тоног төхөөрөмж 21.0 хувиар нэмэгдэж, сургалтын таатай орчин бүрдсэнээр хүүхдэд бүрт хүртээмжтэй, танхим, мультимедиа технологид суурилсан интерактив хичээл, хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт нийцсэн сонирхолтой хичээлүүд заагдаж, багш нарын мэргэжил арга зүй, хичээлийн бэлтгэл, идэвх сайжирч, хүртээмж 35.0 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Шинээр 1 сургууль, 3 цацэрлэг, 2 дотуур байр барихад улсын төсвөөс 3.5 тэрбум, 4 сургууль, 2 цацэрлэгийн их засвар 1.5 тэрбум төгрөгийн зарцуулан ажиллалаа. 2023 онд үргэлжилнэ.	90
-------	---	----------	---------	---	------	--	------	--	--	----

**Зорилт 1.2.** Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх

1.2.1	Эрүүл мэндийн салбар орчин үеийн стандартад нийцсэн барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдан эмчилгээ, оношлогооны шинэ технологи нэвтрэх, үйлчилгээний нэр төрөл олширсон байна.	4,100.7	3,604.3	Шинэ барилга болон их засвар хийгдсэн барилга байгууламжийн тоо, Салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалтын хувь	2020	УТХО-аар барилгын их засвар 5, орон нутгийн төсвийн санхүүжилтаар өргөтгөлийн барилга 1, тоног төхөөрөмжийн хангалт 84%	2022	1 эрүүл мэндийн төвийн барилгыг барих, 2 барилгын их засвар хийгдэж, 3 мөргийг ашиглалтад байна. Тоног төхөөрөмжийн стандарт хангалт өмнөх оноос 2.5 хувиар өссөн байна.	2022 онд эрүүл мэндийн салбарт нийт 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс улсын төсвөөс 3.1 тэрбум, орон нутгийн төсвөөс 405.8 сая, хандив тусламжаар 30.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж салбарын хэмжээнд дараах чиглэлээр үр дүнд хүрсэн томоохон ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 10 ортой эмнэлгийн барилгын суурийг тавьж, Нийгмийн эрүүл мэндийн дэмжих төвийн барилгын их засвар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн их засвар, Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн мөргийн барилгыг барьж дуусган ашиглалтад өгөөд байна. Эрүүл мэндийн салбарт 2022 оны жилийн эцсийн байдлаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нэн шаардлагатай 64 нэр төрийн тоног төхөөрөмжийн 987.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс 78.0 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 22.0 хувь нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдээд байна. Үүний үр дүнд сумдын эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн стандарт хангалт өмнөх оноос 2.6 хувиар өсөж 86.3 хувьд хүрлээ. Тэшиг, Хутаг-Өндөр, Орхон, "Цоожд", "Эмийн цэцэглэн" өрхийн эрүүл мэндийн төв зэрэг 10 сумын эрүүл мэндийн байгууллагыг нийт 86.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Мобайл тоног төхөөрөмж"-өөр хангаж, хөдөөгийн алслагдсан багийн иргэд эрүүл мэндийн үйлчилгээг цаг алдалгүй хурдан шуурхай авах нөхцөл бүрдэж багийн эмч нарт зайнаас оношилгоо эмчилгээг хийх боломжийг олгосон.	70
1.2.2	Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсрол дээшилж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх замаар халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд иргэдийг бүрэн хамруулсан байна.	10.0	35.3	Халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэгийн хувь. Зохион байгуулах сургалт, ярилцлага, аяны тоо.	2020	Халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэгийн хувь -77%. Зохион байгуулсан сургалтын 324, ярилцлага хэлэлцүүлэл 8, аяны тоо 6	2022	Халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэгийн хувийг хамрагдавал зохих хүн амын 80%-д хүргэнэ. Уулзалт ярилцлага хэлэлцүүлэг, аяныг өрнүүлж, 500 сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хийнэ.	Халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэгт хамрагдавал зохих хүн амын 83.0 хувийг хамруулсан. Цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдавал зохих иргэдийн 88.7 хувийг хамруулж шинээр 78, чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэгт 88.2 хувийг хамруулж, шинээр 5 иргэн оношлогдсон. Умайн хүзүүний өмөнгийн үзлэгт 70.0 хувь, хөхний өмөнгийн үзлэгт 85.2 хувийг хамруулж нэгдсэн өвчлөлийг харьяа Эрүүл мэндийн байгууллагын эмчийн хяналтад авч, шат дараатай эмчлэн эрүүлжүүлж байна. "Элэг бүтэн Монгол" хөтөлбөр хэрэгжсэнээс хойш аймгийн хэмжээнд 15-аас дээш насны 44714 иргэн үзлэгт хамрагдахаас 26751 буюу 59.8 хувийг хамруулсан нь зорилтот түвшинээс 1.8 пунктээр нэмэгдсэн. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг төрийн болон ТББ, иргэдийн дунд 23 зорилтот сэдвээр зохион байгуулан, уулзалт, ярилцлага хэлэлцүүлгийг 3 удаа, нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдөрүүд 23, нэрэмжит сарын аян 11 удаа, хөдөлгөөнт болон цахим сургалт 563 удаа зохион байгуулж сурталчилгаанд давхардсан тоогоор 74017 иргэнийг хамруулсан. Аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгааны 13 төрлийн 18816 санамж, 16 төрлийн 12000 зурагт хуудас, давхардсан тоогоор 20 мянга гаруй зөвлөмж, зурагт хуудсыг иргэд, олон нийт, үйлчилгээний байгууллагууд байршуулсан. Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо 8.1 хувиар, иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийн түвшин 2021 оныхоос 5.8 хувиар өссөн байна.	90
1.2.3	Эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай боловсон хүчнээр бүрэн хангагдаж, тэднийг чадавхижуулах, өндөр хөгжилтэй оронд сурах боломж бүрдэн, нийгмийн баталгаа хангагдсан байна.	27.5	19.6	Хүний нөөцийн хангалтын хувь, Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	2020	Хүний нөөцийн хангалт 82%, Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо-720	2022	Хүний нөөцийн хангалт 85.0%, Эрүүл мэндийн салбарын 800-аас дээш ажилтныг чадавхижуулах сургалтад хамруулна.	2022 онд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт стандарт шаардлагаар 87.0 хувьд хүрсэн. Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, үр чадварыг сайжруулах зорилгоор төгсөлтөй дараах үндсэн мэргэшил олгох сургалтад 7 их эмч, төрөлжсөн мэргэшил олгох сургалтад 5 их эмч, 11 сувиллагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 их эмч, 6 сувиллагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, үүнээс гадна ажлын байрны болон танхимын "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага", "Коронавируст халдварын үеийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт", "Коронавируст халдварын эмнэлзүйн удирдмалын хэрэгжилт", "Эмнэлгийн тусламж үйлчилгээн дэх хүний эрхийн асуудал" зэрэг сэдвэд 45 удаагийн сургалтад давхардсан тоогоор 706 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Аймгийн хэмжээнд 183 сувиллагч, 128 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд сувиллагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хангалт 85-90.5 хувьтай байна. Цаашид эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх, чадавхижуулах зорилгоор аймгийн хэмжээнд нэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнүүдийг суралцуулах саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж, "Хамтын ажиллагаатай Булганчууд 2022" арга хэмжээний хүрээнд Бүгд найрамдах Солонгос улстай хамтын ажиллагаа өргөжүүлэх хамтран ажиллах гэрээ байгуулж, олон улсын түвшинд нэвтэрч байгаа эмчилгээ, оношлогооны орчин үеийн аргын талаар мэдлэгтэй болох нөхцөл бүрдсэн. Мөн АШУҮИС болон Этүгэн их сургуультай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан, орон нутагт ажиллах 2 сувиллагчийг элсүүлсэн нь сувиллагчийн хангалтыг нэмэгдүүлэх ажлын нэг үр дүн юм.	94.1

**Зорилт 1.3.** Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, үндэсний өв уламжлалыг залгамжлан, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагыг хослуулан хөгжүүлэх

1.3.1	Үндэсний болон анхдагч түмний бахархал, монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэн, угийн бичгээ хөтөлгөдөг үндэсний уламжлалыг сэргээн, үндэсний болон орчин үеийн соёл, урлаг хослон хөгжсөн байна.	10.0	4.6	Үндэсний бичиг болон угийн бичгийн сургалтыг явуулж, аймгийн хүн амын 30-аас доошгүй хүнийг хамруулсан байна.	2020	Үндэсний бичгийн сургалт явагдаагүй, угийн бичгийн сургалт жилд 2 удаа хийгддэг.	2022	Үндэсний бичгийн сургалтад төрийн албан хаагчдын 70 хувийг, угийн бичгийн сургалтад өрхийн 10 хүртэлх хувийг хамруулна.	Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд СӨБ, ЕБС-ийн багш, сурагчид, ажилтан албан хаагч нар болон төрийн байгууллагуудын албан хаагч нарт зориулан цахим 2 хуудсаар дамжуулан үндэсний бичгийн 21 ширхэг унших бичвэр, эх хэлээ эрхэмлэн дээдлэх уриалга 4 хичээлийг байршуулж, 16 сургагч багш бэлтгэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд анхан, дунд, ахисан түвшний сургалтуудыг явуулж, давхардсан тоогоор 1800 орчим хүнийг хамруулна. Мөн үндэсний бичгийн олон төрөлт тэмцээний зохион байгуулж, бүтээлийн үзэсгэлэн гаргасан. "Үндэсний бичиг үсгийн баяр-2022" үйл ажиллагааг зохион байгуулж, сумын Засаг даргын Тамгын газрын багуудын дунд "Үндэсний бичиг-Бидний бахархал тэмцээн", ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан, 5-8 дугаар ангийн сурагчдын дунд угийн утга тайлбарлан тэмдэглэл хөтлөх тэмцээн, байгууллагууд "Өнө мөнхийн хэл" цахим аянд хамрагдаж, эх хэлээ сурталчлах янгуудыг зохион байгуулаад байна. "Үгийн ид шид" уралдаанд 500 гаруй бүтээл, эсээ бичлэгийн уралдаанд 90 гаруй бүтээл, цахим уралдаанд 2 байгууллага, "Үндэсний бичиг-Бидний бахархал" тэмцээнд 100 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн 700 гаруй оролцогчдыг хамруулан 4.6 сая төгрөгийг зарцуулсан. Сумдын төрийн албан хаагчдаас унших чадварын ахиц амжилтын судалгааг 10 дугаар сард зохион байгуулж, тандан судалгаагаар унших бичиг чадвар 32.0-34.0 хувьд хүрсэн байна.	50
-------	---	------	-----	---	------	--	------	---	---	----

1.3.2	Стандарт шаардлагад нийцсэн барилга байгууламжийн тоог нэмэгдэж, салбарын материаллаг бааз бэхжин соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаа өргөжсөн байна.	1,313.3	725.0	Ажлын гүйцэтгэлийн хувь	2020	Бугат сумын соёлын төвийн барилгын зураг төсөв хийсэн, Хишиг-Өндөр сумын соёлын төвийн барилгын их засварын ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна. 2008 оноос хойш тоног төхөөрөмж шинэчлэгдэж.	2022	3 сумын соёлын төвийн барилгын ажил, их засварыг хийж дуусгах, 2 сумын соёлын төвийн барилгын их засварын зураг төсвийг бэлэн болгох, 7 сумын соёлын байгууллагын тоног төхөөрөмж шинэчилнэ.	2022 онд Бугат сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилгыг улсын төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж, барилгын ажлын гүйцэтгэл 30.0 хувьтай явагдаж байна. Сэлэнгэ сумын соёлын төвийн дэвэрийн засварыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хурмастын хүлэг" ХХК хийж гүйцэтгэлээ. Баяннур сумын соёлын төвийн засварын ажлыг орон нутгийн төсвөөс 199.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Тусток" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажил 60.0 хувьтай явагдаж байна. Тэшиг сумын соёлын төвийн их засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангаас 15.0 сая төгрөгөөр "Дорнын цэнхэр тал" ХХК хийж гүйцэтгэлээ. Хутаг-Өндөр сумын соёлын төвийн их засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангаас 46.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хурмастын хүлэг" ХХК 1 дүгээр ээлжинд их заалны тайзны дэвэр, номын сангийн тааз засварлан, "Баатар ван" амралт сувилалын газар нийгмийн хариуцлагын хүрээнд 30.0 сая төгрөгөөр их заалны шалны ажлыг гүйцэтгэлээ.	70
1.3.3	Орон нутгийн соёлын байгууллагууд, иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилан соёлын өвийг хамгаалалтад авч, соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхи бэхжиж, цахим соёлын сан бүрдсэн байна.	5.0	2.3	ТСҮХДЗ хамгаалагч 20, Соёлын өв тээгч 20 хүнд батламж талархал олгох, цахим соёлын санг бүрдүүлсэн байна.	2020	Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл 3058, цахим бүртгэл мэдээллийн санд 175 өвлөн уламжлагч бүртгэлтэй.	2022	2-оос доошгүй ТСҮХДЗ-ийг сэргээн засварлах, өв тээгчдийн цахим бүртгэлийг шинэчилнэ.	Булган сумын хэмжээнд шилдэг 8 өвлөн уламжлагчийг журмын дагуу сонгож, аймгийн Хөгжимт жүжгийн театрт тайлбар концерт тоглох, 8 өвлөн уламжлагчийг улсын төсвөөс 527.0 мянган төгрөгийн дурсгалын зүйлээр урамшуулсан. Мөн 11 дүгээр сард Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд аймгийн хэмжээнд 5 шилдэг өвлөн уламжлагчийг орон нутгийн төсвийн 1.5 сая төгрөгөөр шагнаж урамшуулаа. Соёлын биет бус өв тээгчдийн бүртгэлийн ich.mongoluv.mn шинэ системийг нэвтрүүлэн өвлөн уламжлагчдын анхан шатны тооллого хийгдэж эхэлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар 3 суманд биет бус өв тээгч 12 хүний мэдээллийг шинээр бүртгэн баримтжуулав. Соёлын биет бус өвийг өвлүүлэх зорилгоор уртын дугуй 54, морин хуурь 36, гар урлалыг 34, шагай харвааг 10 хүн тус тус сургаж байна. Үндэсний өв соёлын унэт зүйлийг хойч үеэс сурталчлан таниулах, өвлөн уламжлагч нараа алдаршуулах өв тээгчийг илрүүлэх зорилгоор өвлөн уламжлагч нарын сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 7-10 дугаар ангийн 321 сурагчийг хамруулсан. Соёлын биет өвийн ich.mongoluv.mn мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх тооллогын ажил 80.0 хувьтай хийгдэж байна.	90
1.3.4	Соёл урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлдэж, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажил зохион байгуулагдаж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байна.	20.0	20.0	Мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлсэн хувь	2020	Мэргэжилтэй боловсон хүчний хангалт 53.0 хувь	2022	Мэргэшүүлэх сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг 1.0 хувиар нэмэгдүүлнэ.	Соёл Урлагийн Их сургууль, Монгол Улсын Консерваторитай хамтран элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 25 хүүхдэд элсэн суралцах урилга гардуулсан. "Булган хангайн хүүхдүүд 2022" урлагийн наадамд оролцсон төгсөх ангийн шилдэг 5 сурагчид МУ-ын Консерваторт 100 хувийн тэтгэлэгтэй суралцах эрх олгов. Соёл Урлагийн Их сургуулиас зохион байгуулсан 5 багц сургалт, Соёл урлагийн газраас зохион байгуулсан 6 чиглэлийн сургалт, Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан 12 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 320 ажилтан, албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлээд байна. Булган аймгийн соёлын салбар дахь 162 албан хаагчаас 94 хүн мэргэжлийн, 68 хүн мэргэжлийн бус байна. Жилийн эцсийн байдлаар мэргэжлийн хүний нөөцийн хангалт 56.0 хувьтай байна.	100
<b>Зорилт 1.4. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, амьдралын салшгүй хэсэг болгож, үндэсний болон өвлийн, зуны спортуудыг дэмжиж, Булган аймгийн баг, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэх</b>										
1.4.1	Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, нийтийн биеийн тамир хөгжиж, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоо аймгийн хэмжээнд бүрдсэн байна.	65.5	65.5	Нийтийг хамарсан тэмцээн уралдаан зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	-	2022	10-аас доошгүй тэмцээн уралдаан зохион байгуулсан байна.	Улсын хэмжээнд зохион байгуулсан "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны хүрээнд аймгийн хэмжээнд 66 байгууллага, аж ахуй нэгжийн давхардсан тоогоор 38000 гаруй ажилтан албан хаагч, иргэд хамрагдаж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дасгал хөдөлгөөн хийж хэвшлээ. Тус арга хэмжээнд 5.6 сая төгрөгийг зарцуулсан. Мөн "Иргэдийн спортын наадам"-ыг спортын 4 төрлөөр зохион байгуулж, 16 сум, төрийн байгууллагын 300 гаруй тамирчид оролцож, 8.0 сая төгрөгийг зарцуулсан. Ардын багш Х.Алтанхуягийн нэрэмжит боксын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаас зохион байгуулж, 33 багийн 226 тамирчин оролцоноос манай аймгийн баг тамирчид 13 медаль хүртэж, багийн дүнгээр 2 дугаар байрт шалгарлаа. Тус арга хэмжээг Монголын боксын холбоотой хамтран зохион байгуулж, 33.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Аймгийн хэмжээнд 54 төрлийн секц дугуйланд 2780 хүүхэд хамрагдаж, 63 багш дасгалжуулагч ажиллаж байна. Үүнээс 2022 оны жилийн эцсийн байдлаар улсын чанартай спортын 12 төрлөөр зохион байгуулсан уралдаан тэмцээнд 947 хүүхэд оролцуулж, 22 алт, 24 мөнгө, 22 хүрэл, нийт 68 медаль авсан амжилт үзүүлжээ. Аймаг, бүсийн чанартай 16 төрлийн уралдаан тэмцээнд 883 хүүхэд оролцож, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 12 спортын холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан улс, бүсийн чанартай 19 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Эдгээр арга хэмжээний үр дүнд улс, бүс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд оролцогчдын тоо өмнөх жилүүдээс 20-30 хувиар нэмэгдэж, үзүүлсэн амжилтын дүнгээр улсын хэмжээнд 4 дүгээр байрт жагсаж байна.	100
1.4.2	Үндэсний спорт болон уламжлалт тоглоом наадаг, олимпын төрлийн спортуудыг бодлогоор дэмжиж, улс, олон улс, тив дэлхийн хэмжээний тэмцээн уралдаанд гаргах амжилтыг ахиулах, аймгийн өсвөрийн шигшээ баг байгуулагдсан байна.	60.0	82.1	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, гаргасан амжилт	2020	Ковидын нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй.	2022	3-аас доошгүй уралдаан тэмцээн зохион байгуулж, улсын тэмцээн уралдаанд баг тамирчдыг оролцуулсан байх, Өсвөрийн шигшээ багийн шалгаруулалтыг явуулна.	2022 онд үндэсний спортын холбоодуудтай хамтран ажиллаж, тэмцээн уралдаанд 73.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээв. Үндэсний бөхийн барилдааныг 29.5 сая төгрөгийн санхүүжилтээр 4 удаа улс, бүсийн хэмжээнд зохион байгуулж, 500 гаруй бөхчүүд оролцсон. Улсын баяр наадмаар шинээр улсын начин цолны болзол хангасан 4 бөхөд 20.0 сая төгрөгийн урамшуулал олголоо. Үндэсний сурын харвааны чиглэлээр улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн 600 гаруй харваачид оролцож, спортын мастер 2 төрөн гарсан. Аймгийн хэмжээнд үндэсний сурын харвааг 4 удаа, сум орон нутагт нэрэмжит тэмцээнийг 3 удаа зохион байгуулж, 300 гаруй харваач хамрагдан 19.6 сая төгрөгийг зарцуулсан. Үндэсний спортын VII наадмын сурын харвааны шигшээ тэмцээнд 16 харваач, мөсний сурын харвааны шигшээ тэмцээнд 12 харваач тус тус оролцлоо. 2022 оны мөсний шугагын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Орхон суманд зохион байгуулж, 60 гаруй тамирчин оролцож, 3.0 сая төгрөг зарцуулав. Үндэсний спортын наадмын шигшээ тэмцээнд мөсний шугагын чиглэлээр 4 тамирчин оролцов. Энэ оны "Хангинахын шугуйн шагайн тойром"-д 500 гаруй харваач, Үндэсний спортын VII наадмын анхан шатны тэмцээнд 100 харваач, шигшээ тэмцээнд 8 харваач оролцож, 5-р байр эзэлсэн байна. Шагайн харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнд 256 харваач оролцож, 2022 онд үндэсний спортын наадамд давхардсан тоогоор 3000 гаруй тамирчид оролцсон нь өмнөх жилүүдтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. 2022 онд аймгийн спортын холбоодын үйл ажиллагаа тогтмолжиж, өмнөх оноос хичээллэгсдийн тоо 5.0 хувиар нэмэгдсэн. Аймгийн өсвөрийн шигшээ багийг спортын /Самбо, жүдо бөх, хөнгөн атлетик, бокс, сагсан бөмбөг, волейбол, цана, тэшүүр, таеквондо, шатар, ширээний теннис, буудлага/ 12 төрлөөр байгуулж, шигшээ багийн 3 багш дасгалжуулагчийн цалинж сар бүр биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрөөс цалинжуулж байна.	100
1.4.3	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдэж, материаллаг бааз бэхжсэн байна.	2,300.0	566.5	Баригдсан болон засвар хийсэн спорт заалны тоо, материаллаг бааз хангалтын хувь	2020	Зураг төсөв хийгдсэн.	2021	Тэшиг сумын спорт заалны барилгын ажлыг эхлүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Тэшиг сумын спорт заалны барилгын ажлыг "Вокон констракшн" ХХК 566.5 сая төгрөгөөр гүйцэтгэж байна. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд шаардлагатай фитнесийн 11 төрлийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 13.8 сая төгрөгийн санхүүжилтээр тохижуулав. Орон нутгийн төсвийн 1.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Биеийн тамир, спортын газрын А заалны үзэгчдийн 400 ширхэг сандыг шинэчлэн тохижуулав.	100
<b>Зорилт 1.5. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин орон нутгийн онцлог тохирсон гарааны бизнесийг дэмжин, шинээр бий болгосон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх</b>										
1.5.1	Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн дэд хөтөлбөр хэрэгжиж, ажил эрхлэлтийн бүртгэл судалгаа мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.	100.0	5.0	Судлагааг хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан байна.	-	-	2022	Судлагааг хийсэн байна.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг "Бүргэд" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, мэдээлэл цуглуулалтыг түүврийн аргаар 1818 нэгжээс авсан. Судалгааны дүнг нэгтгэн аймгийн хөдөлмөрийн эрхлэлтийн зөвлөлд танилцуулж, албан хэрэгцээнд зориулсан эмхэтгэл гаргахад бэлэн болгоод байна.	100

1.5.2	Төр, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн 3 талт хамтын ажиллагааг сайжруулан, сумдын салбар зөвлөлүүд чадавхижсан байна.	10.0	15.0	Салбар хоорондын хамтын ажиллагааны хэрэгжилтийн хувь	2020	80 хувь	2022	85 хувьд хүргэнэ.	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг 13 суманд байгуулж, хэлэлцээрт заагдсаны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд эрүүл мэндийн салбарт хамтарсан үзлэг шалгалтын ажлыг явуулж, үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Мөн 3 талын төлөөллийг чадавхижуулах сургалтыг 4 дүгээр сард цахимаар зохион байгуулж, сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн 87 гишүүнийг хамруулан мэдлэг, мэдээллээр хангав. 2022 онд 3 талын төлөөлөл хамтран "Хөдөлмөрлөх эрх, тулгамдсан асуудал, шийдлийн гарц" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийн хэрэгжилт 93.0 хувьтай байна. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгаас 15.0 сая төгрөг зарцууллаа.	100
1.5.3	Өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол, боломжтой иргэд, гарааны бизнесийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байранд зуучлах замаар 5000-аас доошгүй ажлын байр бий болсон байна.	4.0	-	Шинээр бий болгосон ажлын байрны тоо, тоног төхөөрөмж хангалтын хэмжээ	2020	457 ажлын байр	2022	Гарааны бизнесүүдийг дэмжих арга хэмжээний тоо, 1300 ажлын байр бий болгосон байна.	Булган суманд "Намрын ногоон өдрүүд-2022" хөдөлмөрийн яармаг, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 19 иргэн, 6 аж ахуйн нэгж, байгууллагын 40 нэр төрлийн бүтээгдэхүүн оролцсоны зэрэгцээ "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд 12 иргэн 16 нэр төрлийн модны тарц суулгац худалдан борлуулсан байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчлах зорилгоор "Булганд үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг Хутаг-Өндөр суманд шинээр байгуулан 96 иргэний 20.7 сая төгрөгийн 110 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээс 7.5 сая төгрөгийн борлуулалтын орлогыг буцаан олгоод байна. "Хангинахын шугуйн шагайн тойром" арга хэмжээний үеэр нийтийн хоолны 14 цэг, худалдаа үйлчилгээний 9 цэг ажиллаж, иргэдэд халуун хоол цай, хүнс, бэлэн хувцасны худалдаа үйлчилгээ үзүүлж, 10.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Мөн нутгийн брэнд бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, Булган сумын "Тунамал өгөөж" ХХК, Хялганат тосгоны "Сүмийн нуга" хоршоо оролцож, 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилжээ. Улаанбаатар хотод "Хамтын ажиллагаатай Булганчууд" үзэсгэлэн худалдаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан 6 иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн айраг, цагаан идээ болон бусад бараа бүтээгдэхүүнээр оролцсон байна. 2022 онд 1300 ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөснөөс давхардсан тоогоор 880 ажлын байрны захиалга авч "Сайхан Монгол" телевиз болон зарын цэгүүд, цахим хуудсанд байршуулан сурталчилж ажилласнаар 1250 шинэ ажлын байр бий болж, гүйцэтгэл 96.1 хувьтай байна. Үүнээс байнгын ажлын байранд 275, улирлын ажлын байранд 220, түр ажлын байранд 755 иргэн ажиллаж байна.	96.1
<b>Зорилт 1.6.</b> Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх халамж хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, хүсийн тэгш байдлыг нийгмийн бүх салбарт хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх										
1.6.1	Аймгийн хэмжээнд гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн бодлогын хэрэгжилт хангагдсан байна.	40.0	36.6	Тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2020	-	2022	Төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувиас дээш байна.	Аймгийн засаг даргын нэрэмжит "Хүрч үйлчлэл" нийгмийн салбарын байгууллагуудын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэн 8 сумын 2800 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлээ. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлуудын үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.4 хувиар буурсан байна. Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл"-ийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж, 21 байгууллага хүүхдийн өрөө тохижуулан, бүх сургууль, цэцэрлэг хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Залуучуудын хөгжлийн дэмжих чиглэлээр жилийн ажлын төлөвлөгөөг гарган модуль сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, сайн дурын залуучуудын клуб байгуулагдаж, салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа эрчимжиж, 11359 залуу буюу нийт залуучуудын 65.4 хувьд хүрч ажилласан байна. Аймгийн "Ахмадын өргөө"-ний үйл ажиллагаа жигдэрч чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдээ, мэдээллээр хангах төрөл бүрийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Ахмад настны өдрийн үйлчилгээнд 29, гэрийн асаргаанд 6, зөвлөх үйлчилгээнд 2 ахмад настан хамрагдсан ба харьяалалгүй 400 ахмад, 90-ээс дээш настай 83 ахмад настан сар шинийн баярыг тохиолдуулан аймгийн Засаг даргын хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Мөн олон улсын ахмадын өдрийн хүрээнд олон төрлийн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж, 500 ахмад настанд нийт 28.0 сая төгрөгийн гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлэв.	100
1.6.2	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендерийн тэгш байдал хангагдсан байна.	10.0	2.5	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	2020	90 хувь	2022	Хөтөлбөрийн хэрэгжилт 80 хувиас дээш байна.	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр 4 зорилтын хүрээнд 21 ажил төлөвлөж, төлөвлөгөөний биелэлт 92.9 хувьтай байна. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан "Харилцан хүндэтгээ" аяныг зохион байгуулж, "Хүчирхийллийн эсрэг хүн бүр гэрэл асаая", "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо манлайлал" хэлэлцүүлэг, Ханддаа захидал бичээрэй захидлын уралдаан, АХА тэмцээн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа. "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо манлайлал" хэлэлцүүлэгт төрийн байгууллагуудын удирдлага, эрэгтэй албан хаагчийн хамт 83 хүн оролцож, "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт", "Эрэгтэйчүүдийн боловсрол", "Эрэгтэйчүүдийн оролцоо, нөлөөлөл" сэдвийн хүрээнд эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлаар хэлэлцэж, гарсан саналуудыг улсын хэмжээний хэлэлцүүлэгт хүргүүлээ. Мөн төрийн албан хаагч эмэгтэйчүүд болон улс төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ЛЭОС болон аймгийн "Монгол хатад гэрэлтүүлэхүй" төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж байна.	92.9
1.6.3	Хөдөөгийн малчин иргэдэд чиглэсэн хандлагаа өөрчлөх "Нөлөөллийн аян" зохион байгуулагдсан байна.	-	-	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, зохион байгуулсан арга хэмжээний тоо	2020	20 хувь	2022	25 хувьд хүргэнэ.	Иргэд олон нийтэд шинээр батлагдсан хууль, журам, төсөл хөтөлбөрийн танилцуулгаа зэрэг мэдээ, мэдээллийг аймаг, сум, байгууллагын цахим хуудас, хаяг болон Facebook хаягаар дамжуулан цаг тухай бүрд нь хүргэж, нөлөөллийн аяны хүрээнд эрүүл мэндийн үзлэг хийж, нийгмийн даатгал, нийгмийн халамж үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Сумын мэргэжилтнүүд багийн иргэдийн нийтийн хурлын үеэр мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласнаар нийт өрхийн 20 хувьд хүрч үйлчиллээ. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ, ажлын байрны зар, бусад цаг үеийн холбогдох мэдээллийг 4860 гаруй өрхөд хүргэж ажиллалаа.	80

1.6.4	Төр хувийн хэвшлийн түншлэлийг хангах, ахмад, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучуудын байгууллагуудыг дэмжих, хамтын ажиллагааг сайжруулах замаар ахмад залуу үеийн залгамж холбоог дээшлүүлэх, Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн байна.	30.0	33.0	Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт хувь	2020	Гэрээний хэрэгжилт 80-аас дээш хувь	2022	90-ээс дээш хувийн хэрэгжилттэй ажилласна.	Төрийн болон улс төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ЛЭОС болон аймгийн "Монгол хатад гэрэлтүүлэхүй" төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал: Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ арга хэмжээг хэрэгжүүлэн аймаг орон нутгийн улс төрийн болон төрийн албаны манлайлагч эмэгтэйчүүдийг татан оролцуулж, шийдвэр гаргах түвшний албан тушаалд горлох, улс төрийн сонгуульд нэр дэвших, улсаар иргэдийн итгэлийг хүлээн хүний эрхэд суурилсан, жендэрийн тэгш байдлын зарчимд нийцсэн, хамтын нөлөөллийн олон талт дэмжлэг үзүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулж байна. 2022 онд аймгийн Ахмадын өргөөний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж аймаг, орон нутгийн зүгээс 25.0 сая төгрөгөөр шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, зарим засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн 10.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүжгийн заалны тохижилтыг хийж, хөгжим хэрэгслээр хангасан байна. Залуучуудын дуу хоолойг хүргэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "NEW STORY" чуулганыг зохион байгуулж 16 сүм 1 тосгон, 13 байгууллагын залуучуудын салбар зөвлөлийн 110 төлөөлөгч залуучууд оролцож, 8 сүм, 28 байгууллага залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулан нийт 11359 залуучууд буюу нийт залуучуудын 65.4 хувьд хүрч ажилласан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал 2022 онд 15 удаа хуралдаж, 154 хүүхдийн асуудлыг хэлэлцэн, шинээр 47 хүүхдэд асаргаа тогтоосон. Энэ онд 217 хүүхэд байнгын асаргаанд хамрагдаж байгаа бөгөөд хүүхдүүдэд төрөлжсөн мэргэжлийн багийн эмч нар нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах талаар зөвлөгөө өгч, хүүхдийн боловсрол хариуцсан мэргэжилтнүүд нийгмийн асуудлын чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэн хамрагдаж төмс хүнсний ногоо тариалах, цайны газар ажиллуулах, хэрчсэн гурил хийх, ноос ноолууран эдлэлээр гар урлал хийх зэрэг чиглэлээр 8.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан.	100
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дотоодын нийт бүтээгдэхүүн жилд дунджаар 10 хувиар өсч, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, хөрөнгө оруулалт нэмэгдсэн аймаг болно.</b>										
<b>Зорилт 2.1. Аймгийн төсөв, санхүүг ил тод, үр ашгийг байлгаж, орон нутгийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх</b>										
2.1.1	Эдийн засгийг жил бүр тогтвортой өсч, ажил эрхлэлт нэмэгдсэн байна.	-	-	ДНБ-ий өсөлт, нэмэгдсэн ажлын байрны тоо	2020	6501.9 мян.төг	2022	7,869.9 мян.төг	Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 оны гүйцэтгэлээр 485.2 тэрбум, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 7.8 сая төгрөгт хүрч, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 21.5 хувиар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 20.9 хувиар тус тус өссөн байна. Үүнээс хөдөө аж ахуйн салбар 14.6 хувь, үйлчилгээний салбар 7.8 хувийн өсөлттэй гарлаа. Байнгын болон түр 1300 ажлын байр нэмэгдүүлж ажиллалаа.	100
2.1.2	Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадвар өссөн байна.	-	-	Орон нутгийн хөгжлийн индексийн үзүүлэлт	2020	Орон нутгийн хөгжлийн индексээр 9-д эрэмблэгдэж байсан.	2022	Эхний 10-т багтсан байна.	Орон нутгийн хөгжлийн индексийн үзүүлэлт улсын хэмжээнд эхний 10-т багтсан үзүүлэлттэй гарлаа.	100
2.1.3	Хөрөнгө оруулалт нэмэгдэж, төр, хувийн хэвшлийн түншлэл хөгжсөн байна.	-	-	хөрөнгө оруулалтын тоо	-	-	2022	хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн байна.	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэл үйлчилгээний 28 цэг шинээр байгуулагдаж, 60 гаруй ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. Хангал суманд "Хялганат эко мах" ХХК нь хоногт 30-50 бод, 100-200 бог мал нядлах хүчин чадалтай, 50 тоннны багтаамжтай хөргүүртэй агуулах үйлдвэр ашиглалтад орсон. Булган суманд "Давших конкрет" ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр ашиглалтад орж, 540 гаруй тн зуурмаг орон нутгийн барилга бүтээн байгуулалтад нийлүүлсэн байна. "Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийн 76.0 сая төгрөгийн хөрөнгөөр өдлийн үйлдвэрийн 20 тоног төхөөрөмж, 26 дагалдах хэрэгслийг авч, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газар, Булган аймгийн хамтын ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 299.8 сая төгрөгөөр өдлийн үйлдвэрийн байртай болж, үйлдвэрийн нээлтийг хийлээ. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээ эрхлэх 1 төсөл 70.0 сая, "Энхжин хүнс" ХХК-ийн гахайн эрчимжсэн аж ахуй, ангилсан махан бүтээгдэхүүний төсөл 100.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Аймгийн "Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэл", сумын тухайн жилд дэмжин хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд Хоршоо хөгжүүлэх сангаас 29 бизнес төсөлд 876.0 сая төгрөгийн зээл олгогдож, чанаргүй зээл өмнөх оноос 10 хувиар буурсан. Булган сумын 6 дугаар баг Чин ван Ханддоржийн өргөн чөлөө 1-р гудамж 109 а тоотод Бизнес хөгжлийн төв буюу ахуйн үйлчилгээний төв барих 654 м.кв газрыг шийдвэрлэж, зураг төсвийг "Аслаан" ХХК 40.5 сая төгрөгөөр гүйцэтгэж байна.	100
2.1.4	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлсэн байна.	-	-	Дотоод худалдан авалт нэмэгдсэн хэмжээгээр	2021	1.7 тэрбум	2022	Дотоодын худалдан авалт өмнөх оноос нэмэгдсэн байна.	Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 13.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 77 төсөл арга хэмжээнээс 68 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч 10.7 тэрбум төгрөгийн гэрээг байгуулж ажилласан. Үүнээс 24 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч 3.7 тэрбум төгрөгийн гэрээт ажлыг гүйцэтгэсэн байна.	100
<b>Зорилт 2.2. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх</b>										
2.2.1	Хариуцлагатай уул уурхай хөгжсөн байна.	224.0	167.0	Хөрөнгө оруулалтын хэмжээ	-	-	2022	Нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө оруулалтууд хийгдсэн байна.	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газраас манай аймагт 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр "Эрдэс байлгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдэл" хэлэлцүүлгийг зохион байгуулан, төрийн байгууллагууд болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 51 хүн оролцлоо. Үүнтэй холбогдуулан Аймгийн Засаг дарга болон Бүрэгхангай, Дашинчилэн сумын Засаг дарга нар уул уурхайн 10 аж ахуйн нэгжтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтын ажиллагааны гэрээг байгуулж, 33 хүүхдийн сургалтын төлбөр, 3 хүүхдийн эмчилгээний зардал болох 224.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэхээр тогтож, 2022 оны эцсийн байдлаар 164.0 сая төгрөг, 30 хүүхдийн сургалтын төлбөрийг дэмжлэг, тэтгэлэг олгоод байна. Бүрэгхангай сум 2022 онд 15 уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээг байгуулан 938.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 541.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.	70
2.2.2	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин нэмэгдэж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт өссөн байна.	-	-	Экспортод гаргасан бүтээгдэхүүний хэмжээ	2020	2017-2019 онд нийт 700 тн мах экспортод гаргасан.	2022	Жилд 100 тн дээш мах, махан бүтээгдэхүүн экспортолсон байна.	"Хутаг- Өндөр мах маркет" ХХК нь Иран улсад 270.0 тн мах экспортод нийлүүлж, аж ахуйн нэгжийн захиалгаар 200 нь мах гулуузан балтгаж нийлүүлсэн.	100
2.2.3	Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал хөгжиж, дотоодын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшлэсэн байна.	224.0	224.0	Дотоодын аялагч жуулчдын тоо	2020	40000	2022	50000	Энэ онд аймгийн хэмжээнд 5 эвент арга хэмжээг төлөвлөн "Хангинахын шугуйн шагайн тойром"-ын арга хэмжээг 5 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Орхон аймагтай хамтарч, 7 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд "RFC MONGOLIA BULGANKHANGAI 2022" олон улсын бартаат замын уралдаан, 8 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд "АЙРАГ НААДАМ" арга хэмжээ, 10 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд "Aragday" арга хэмжээ, 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд "ITM Mongolia 2022" арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Эдгээр эвент арга хэмжээг зохион байгуулахад 224.0 сая төгрөгийг зарцуулан ажиллаж, гадаадын 8500, дотоодын 100000 орчим аялагчид эвент арга хэмжээнүүдийг үзэж сонирхохоор зорин ирсэн байна.	100

2.2.4	Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтэц хөгжсөн байна.	-	-	Эрчим хүч, инженерийн дэд бүтцийн сайжруулалт, шинэчлэлтийн хувиар	2020	-	2022	Цахилгаан, эрчим хүчний хангамжийг сайжруулж, найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.	Дашинчилэн сумын хатуу хучилттай авто зам улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна. Дэлхийн банкны төслөөр хэрэгжиж буй ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 4770 хэрэгжлийг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэхээр төлөвлөсөн ба 2022 онд төслийн хүрээнд төмөр бетон тулгуур, 0.4 кВт-ын 7 км кабель, 10 кВт-ын 2 км кабель болон 400 кВт, 250 кВт, 160 кВт-ын нийт 8 дэд станцын ажлыг бүрэн гүйцэтгээд байна. Гэр хорооллын айл өрхөд 2 тарифт тоолуур суурилуулах ажил энэ оны эхний 11 сарын байдлаар 87.0 хувьтай хийгдэж байна. Бугат сумын Ханжаргалант багийг цахилгаан эрчим хүчинд холбох тус ажлыг "ЖЕММН" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд импортын бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээс шалтгаалан ажил удаширж байна. Сайхан, Хутаг-Өндөр сумын заагт орших "Дондогийн булаг" орчмыг цахилгаан эрчим хүчний системд холбох ажлыг "Виртуал софт" ХХК гүйцэтгэж байна.	100
2.2.5	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлсэн байна.	-	-	Түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн хэмжээ	2020	-	2022	Үндэсний үйлдвэрт нийлүүлэх арьс шир, ноосны нийлүүлэлтийг тасралтгүй нэмэгдүүлсэн байна.	Давхардсан тоогоор 2300 малчин өрх, үйлдвэрт 1.3 мянган тн ноос, 85000 ширхэг арьс шир нийлүүлсэн байна. 2022 онд 4230 өрхийн 1.8 сая тонн ноосонд 1.8 тэрбум төгрөгийн урамшуулал, 3800 малчин өрх 320.0 сая төгрөгийн арьс ширний урамшуулалд хамрагдсан. Хөдөө аж ахуйн түүхий эдийн урамшуулал цахимжиж E_mongolia-аар дамжин, олгогдож байгаатай холбогдуулан урамшуулалд хамрагдалт бага байна.	70
<b>Зорилт 2.3. Хөдөө аж ахуйн байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвар бүхий тогтвортой үйлдвэрлэлтэй, эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх</b>										
2.3.1	Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөц чадавхжиж, хөдөлмөрийн үнэмлэж нэмэгдэн, залгамж халааг бэлтгэж, хөгжүүлсэн байна.	-	-	Чадавхжуулах сургалтад хамрагдсан хүний тоо	2020	Давхардсан тоогоор 350 албан хаагч, малчдыг сургалтад хамруулсан.	2022	350-аас доошгүй МАА-н мэргэжилтэн, малчдыг хамруулна.	Аймгийн хэмжээнд мал зүйч, газар тариалан, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн тус бүр 16 ажиллахаас мал зүйч 10, газар тариалангийн мэргэжилтэн 11, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн 11 ажиллаж байна. Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран дутагдалтай байгаа орон тоог нөхөж ажиллуулах, давтан сургах, шинээр төгсөгчдийг орон нутагтаа ажиллахад уриалах ажлуудыг зохион байгуулж байна. Энэ онд аймгийн Тариаланчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, 350 тариаланч, аж ахуйн нэгж, байгууллага оролцож, цаашдын үйл ажиллагааны талаар санал солилцон, 2022 онд баримтлан ажиллах нэгдсэн уриалгыг гаргасан. Мөн Бугат, Бүрэгхангай, Орхон, Рашаант, Сэлэнгэ сум "Төлчин эмэгтэйчүүд" зөвлөгөөнийг зохион байгуулж, 1200 малчин хамрагдлаа. Шинэ Зеланд улсын "Шэйр Монголиа" төрийн бус байгууллагын мэргэжлийн багш нар цахилгаан хайчаар хонины ноос хяргах, ноос ангилах олон улсын туршлагыг нэвтрүүлэх зорилгоор хонины ноос хяргах сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Дашинчилэн суманд зохион байгуулж, 15 малчин залуус хамрагдан, сертификат, 4 ширхэг иж бүрэн ноос хяргах тоног төхөөрөмж авсан.	100
2.3.2	Малын чанар, ашиг шим сайжирч, генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлсэн байна.	-	-	Өндөр ашиг шимт малын эзлэх хувь	2020	Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээ-20	2022	Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээ 22-д хүргэнэ.	Нийт мал сүргийн 1.2 хувь нь цэвэр эрлийз үүлдрийн, 21.3 хувь нь сайжирсан үүлдрийн, 77.4 хувь нь нутгийн монгол мал байна. Гурванбулаг сумын "Блек ангус" ХХК өнгөрсөн жил Лимузын, Хар ангус үүлдрийн үхрийн 37 тугал бойжуулан, 30 үнээнд зохиомол хээлтүүлж хийсэн байна. Махны үхрийн 1 аж ахуйн нэгж, 5 иргэний 515 толгой үхэр, сүү-махны үхрийн 1 аж ахуйн нэгж, 12 иргэний 455 толгой үхэр, сүүний үхрийн 1 аж ахуйн нэгжийн 57 үхэр, нарийн, нарийвтар ноост хонины 1 аж ахуйн нэгжийн 200 толгой хонийг цэвэрээ нь урхүүлж байгаа нь өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээг 22.5-д хүргэж байна.	100
2.3.3	Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийг хамгаалах, хадлан тэжээл, усны хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэл буурсан байна.	-	-	Малын тэжээл тариалсан талбайн хэмжээ	2020	Малын тэжээл 2.5 мянган га талбайд тариалсан.	2021	Малын тэжээл 3.5 мянган га талбайд тариалсан байна.	Аймгийн хэмжээнд 363 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 28 худаг гаргаж, бэлчээрийн 37.8 мянган га талбайг усжуулсан. Бэлчээрийн даацыг бууруулахаар жил бүр 715.0 мянган мал заа эзлэд борлуулдаг бөгөөд бод мал 78.8 мянган толгой, бөг мал 636.2 мянган толгой, дотоодын хэрэгцээнд 474.0 мянган толгой мал хэрэглэж байна. Энэ онд 1.2 сая толгой мал эдийн засгийн эргэлтэд оруулахаар урьдчилсан тооцоо гарсан. Бэлчээрийг нөхөн сэргээх ажлын хүрээнд 3324 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж, 12250 тн ургац хураан авсан.	94.2
2.3.4	Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, бүс нутгийн түвшинд халдварт өвчнөөр тайван байдал баталгаажсан байна.	607.6	903.9	Мал, амьтны өвчлөлийн бууралтын хувь	2020	Нийт өвчлөлийн 2 хувь	2022	Өвчлөлийг 1.98 хувь хүртэл буурна.	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн 607.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1.4 сая мал амьтан хамруулахаар төлөвлөснөөс 1.39 сая мал амьтан, Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 4.0 сая мал амьтан хамруулахаар төлөвлөснөөс 3.1 сая мал амьтан, улсын төсвийн 296.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 362.0 мянган толгой мал хамруулахаас 343.9 мянган толгой мал, Бруцеллээ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 773.4 мянган толгой мал хамруулахаас 744.7 мянган толгой мал, амьтан хамруулснаар өвчний гаралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар буураад байна.	100
2.3.5	Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалт сайжирч, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	-	-	Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтын хэмжээ, голлох нэр төрлийн таримлын тариалалт нэмэгдсэн хэмжээ	2020	Тариалангийн талбайн ашиглалт 91 хувь	2022	Тариалангийн талбайн ашиглалт 92 хувь хүргэнэ.	Аймгийн хэмжээнд 119.7 мянган нэгж талбай байдгаас 99.0 мянган га талбайг ашиглаж, жилд 43.0-49.6 мянган га талбайд тариалж, 39.5 мянган га талбайд уринш бэлтгэж байна. Энэ онд 540 га-д төмс, 220 га-д хүнсний ногоо тариалахаар төлөвлөснөөс төмс 469 га-д тариалж, 3362.7 тн, хүнсний ногоо 293.4 га-д тариалж, 2019.2 тн-ыг тус тус хураасан нь өмнөх оноос 151.5 тонноор нэмэгдэж, хүн амын хүнсний ногооны 38.0 хувийг хангаж байна.	100
<b>Гурав. НОГООН ХӨГЖИЛ. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройлтыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.</b>										
<b>Зорилт 3.1. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэх</b>										
3.1.1	Тусгай хамгаалалттай газар нутгийн сулжээг өргөтгөж, нийт газар нутгийн 20-оос доошгүй хувийг тусгай хамгаалалтад авсан байна.	-	-	Хамгаалалтад авсан нийт газрын хэмжээ	2019	16.13	2022	Бүрэнгийн нуруу орчмыг орон нутгийн тусгай хамгаалалтад, Тэшиг сумын Дулаан хаан уул орчмыг улсын тусгай хамгаалалтад авна.	Тэшиг сумын ИТХ-ын тогтоолоор Дулаан хаан уул орчмын 15516.6 га, Гурванбулаг сумын зарим газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит XII хуралдаанаар хэлэлцүүлэн XII/23 дугаар тогтоолоор батлуулав. Баян-Агт сумын Дулаан хаан уул орчмын 17049.6 га, Цэгээн нуур орчмын 23485.69 га, Шарга нуур орчмын 3669 га, Цагаан голын рашаан, Хайлааст тохой орчмын 415.85 га, Хануй рашааны дэнж, Хүрэн толгой орчмын 454.6 га газрыг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авч сумын ИТХ-аар батлуулан холбогдох материалыг Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газарт хүргүүлээ.	70
3.1.2	Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээсэн байна.	-	-	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ	2020	103.9	2022	Бүрэгхангай сумын Дорст багийн нутаг дэвсгэрт 40 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Бүрэгхангай, Дашинчилэн сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд 41 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөснөөс биологийн 12.1 га, техникийн 31.5 га газрыг нөхөн сэргээлт хийж 3 булаг шандны эхийг хашиж хамгаалан нийт 23600 ширхэг мод бутыг тариад байна.	100
3.1.3	Нэн ховор, ховор, зэрлэг амьтдыг хамгаалах, нутагуулан урхуулж, агнуурын ан амьтдын сүргийн бүтэц, тоо толгойг зохистой хэмжээнд барьсан байна.	15.0	15.0	Хөрөнгийн хэмжээ	2020	10	2022	Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Рашаант сумдын нэн ховор, ховор амьтад тархсан газар нутагт 3 удаа зохион байгуулна.	Орхон сумын 3-р багийн Өрөмийн адагт Хустайн нурууны байгалийн цогцолборт газраас 50 тарвага сэргээн нутагшуулсан. Аймгийн ИТХуралдааны V/04 дугаар тогтоолын нэн ховор, ховор, зэрлэг амьтад биотехникийн арга хэмжээ зохион байгуулах 15.0 сая төгрөгийн бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Хөгнө-Тарны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээ байгуулан 10 тонн өвс, 10 тонн давс, жүжир, 5 тонн тэжээлийн будаа, 63 цэг мараэнд тавьж биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Ахуйн зориулалтаар агнах, барих зөвшөөрлийг БОАЖЯ баталсан хуваарьт багтаан иргэн хуулийн этгээдэд олгож гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллалаа.	100
3.1.4	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн болон зам, барилгын ажилд ашигласан орд газар, карьеруудын нөхөн сэргээлт хийгдсэн байна.	-	-	Хүлээж авсан нөхөн сэргээлтийн талбайн хэмжээ	2020	218.9	2022	Төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авсан байна.	Бүрэгхангай, Дашинчилэн, Сэлэнгэ сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 13 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөлтэй талбайн төлөвлөгөөгөөр 128.4 га техникийн нөхөн сэргээлт, 90.2 га биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөснөөс техникийн нөхөн сэргээлт 128.8 га, биологийн нөхөн сэргээлт 118.5 га талбайд гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийг ажлыг хүлээн авч ажиллалаа.	100

3.1.5	Ойн сангийн талбайн хэмжээ нэмэгдсэн байна.	298.5	293.2	Ойжуулсан талбайн хэмжээ	2019	39.4	2022	39.48	Бугат, Орхон, Бүрэгхангай, Сэлэнгэ сумдад бортогтой тарьцаар ойжуулалтын ажлыг 35 га, Сэлэнгэ, Бугат сумдад суулгацаар ойжуулалтын ажлыг 20 га, Орхон, Бүрэгхангай сумдад 50 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил. Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сэлэнгэ сумдын мод бэлтгэлийн аж ахуй нэгжүүдийн хөрөнгөөр 47.5 га талбайд тус тус ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэжээ.	100
3.1.6	Усны хуримтлал, ус хангамж нэмэгдэж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежмент хэрэгжсэн байна.	68.0	-	Хашиж хамгаалсан булаг шандын тоо	2020	10	2022	10 булаг шандыг хашиж хамгаална.	Аймгийн ИТХ-ын хуралдааны IX/16 дугаар тогтоолоор 68.0 сая төгрөгийг батлуулан Баян-Агт, Баяннуур, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Хишиг-Өндөр суманд 10 булаг шандын эхийг хашиж хамгаалах тендерийн ажлыг 3 удаа зарласан боловч бараа материалын өсөлттэй холбоотой гүйцэтгэгчээр компани ороогүй тул шинээр усны эх үүсвэрийн хамгаалалтын хашааны зураг төсөл боловсруулан дахин тендер сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна.	30
3.1.7	Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэх замаар эдийн засгийн хүртээмж нэмэгдсэн байна.	600.0	600.0	Түр буудаллах цэгийн тоо	2020	1	2022	Буудаллах цэгийн тоог 1 ээр нэмэгдүүлсэн байна.	2021-2022 онд Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт улсын төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгөөр түр буудаллах цэг байгуулж, цахилгаан эрчим хүчний шугам татах ажлыг гүйцэтгэн энэ оны 5 дугаар сард хүлээж авлаа. Мөн 2022 онд улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Рашаант сумын Элсэн тасархайд "Өвөлжөөн булаг" ХХК, Баян-Агт сумын Хануй рашааны дэнж дээр "Цонхот" ХХК отоглох цэг байгуулах ажлыг гүйцэтгэн хүлээлгэж өгөв.	100
3.1.8	Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, байгаль хамгаалалд иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.	5.0	5.7	Сургалт, сурчиглаа явуулсан тоо	2020	2 удаа	2022	Аймгийн веб хуудсанд 600 аас доошгүй мэдээ оруулж 50000 аас доошгүй иргэн, аж ахуй нэгж байгууллагыг мэдээллээр хангана.	Аймгийн хэмжээнд "Тэрбум" мод, "Аялал жуулчлалын жил", "Цэвэр орчин- цэмцгэр Булган" аяны жилийн ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 16 сум 1 тосгонд хавар, намар 2 удаагийн сургалт мэдээллийн ажлыг хийж 700 гаруй иргэдийг мэдээллээр хангасан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/475, А/663 тоот захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтарсан шалгалтыг 3 удаа, сум, сумд дундын ойн ангийн хамтарсан шалгалтыг 19 удаа хийж 77483.7 мянган төгрөгийн нөхөн төлбөр, 3110.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, хяналт шалгалтыг эрчимтэй зохион байгуулж орон нутгийн төсөвт орох орлогыг нэмэгдүүлэн ажиллалаа. Байгаль орчин, аялал жуулчлалын пэйж хуудас болон nature.bu.gov.mn веб хуудсанд нийт 603 мэдээлэл оруулж 85952 хүн мэдээллийг үзсэн байна.	100

**Зорилт 3.2. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашгийг цэвэр технологи нэвтрүүлэх**

3.2.1	Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээ өргөжиж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэл буурсан байна.	-	-	Урьдчилсан мэдээний чанар илрүүлэлтийн хувь	2020		2022	Урьдчилсан мэдээний чанар 70%, онч 85%, илрүүлэлт 90% байна.	Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх чадамжийг сайжруулах үүднээс цаг уурын автомат станцуудын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Энэ онд урьдчилсан мэдээний чанар 90.4, онч 100, илрүүлэлт 100 хувьтай байна. Цаг агаарын мэдээ мэдээллээр үйлчлэх ажлыг өргөжүүлж, вэб сайт (www.bulgan.tsag-agaar.gov.mn), Цаг агаар аппликэйшн, "Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв" цахим хуудсаар хагас хоног болон 1-5 хоногийн урьдчилсан мэдээ тус бүр 365, 7 хоногийн урьдчилсан мэдээ 52, сарын урьдчилсан төлөв 12, улирлын урьдчилсан төлөв 9, өнгөрсөн хоногийн тойм 365, 7 хоногийн тойм 52 удаа тус тус гаргаж үйлчилсэн. Мөн хавар, намрын улиралд түймрийн эрсдэлийн заргийг 186 удаа бодож, холбогдох газарт уламжилсан бөгөөд цаг агаарын мэдээллийг сардаа 30 мянган хэрэглэгч ашиглаж байна. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулга мэдээ 14, сэрэмжлүүлэг мэдээ 7, урьдчилан сэргийлэх мэдээ 1 удаа гаргаж, цаг тухайд нь багц мессежээр давхардсан тоогоор 66 байгууллага, 213140 иргэнд өгч үйлчилсэн байна.	100
3.2.2	Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин боловсруулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	650.0	650.0	Дахин боловсруулсан хог хагдлын хувь	2018	7.6	2022	30.45	Аймгийн Засаг даргын 2022 оны А/88 дугаар захирамжаар "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг аймгийн хэмжээнд 02 дугаар сарын 10-аас 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал зохион байгуулж, 24026.8 га газрын 1752.0 тн, 2 нуур, 91 гол горхи, уст цэгийн 155.8 тн хог хаягдлыг цэвэрлэн хогийн төвлөрсөн цэгт хүргэж, үхсэн бод малын 894, бог малын 4155 сэг зэм, 375 нохой, 39 муур устган халдваргүйжүүлж, энэ ажилд 318 аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон төрийн албан хаагч 5609 хүн, 231 автомашин техник оролцож, 34.2 сая төгрөг, 3445 л шатахуун зарцуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 9 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор 2022 оны 09 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, гол горхи, усан сан бүхий газрын 2261.5 га, улсын болон орон нутгийн зам, хүмүүс ихээр зорчдог уул, овооны орчмын 2570 га газрын 126.8 тн хог хаягдлыг цэвэрлэж, цэвэрлэгээнд 1760 гаруй хүн, 75 техник хэрэгсэл оролцлоо. 2022 онд орон нутгийн төсвийн 650.0 сая төгрөгөөр Баян-Агт, Бугат, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Тэшиг сум, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум, Хялгант тосгонд хог ачиг зориулалтын автомашин нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Цаст Хан Хөхий" ХХК шалгаран гэрээ байгуулав. Автомашинуудыг БНХАУ-ын Эрзэн хотын хилийн боомтод авчирсан боловч коронавируст цар тахал өвчний улмаас тус улсад хорио цэврийн дэглэм тогтоож, хил гааль хаасантай холбогдуулан гэрээний хугацааг ирэх оны 1 дүгээр сар хүртэл сунгаад байна.	90
3.2.3	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг эко шийдэл бүхий ариун цэврийн байгууламж, инженерийн хангамжтай болсон байна.	78.0	78.0	Эко жорлонгийн тоо	2020	-	2022	18	Булган суманд 9 байршилд соруулдаг 18 соруулдаг боловсон жорлонг барьсан. Мөн Булган, Орхон суманд үйл ажиллагаа явуулдаг 10 шатахуун түгээх станц нүүхэн жорлонг буулган соруулдаг боловсон барьлаа. Рашаант сумын Элсэн тасархай, Баян-Агт сумын Хануй рашааны дэнжд БОАЖЯ-ны санхүүжилтээр аялагчдад зориулсан отоглох цэг байгуулж, тус бүр 8 суудалтай соруулдаг боловсон жорлон барьсан. Хутаг-Өндөр сум Их булаг рашааны орчимд үйл ажиллагаа явуулдаг 6 иргэн аж ахуйн нэгж, байгууллага нүүхэн жорлонгоо эко боловсон 00-той болгоод байна.	100
3.2.4	Зарим багийн төв болон суурин газруудыг сэргээхэд эрчим хүчний эх үүсвэртэй болгох асуудлыг судалж, хэрэгжүүлсэн байна.	-	-	Гүйцэтгэлийн хувиар	2020	-	2022	Төслийн ТЭЗҮ, Зураг төсвийг холбогдох яамдуудад уламжлан шийдүүлсэн байна.	Шинэ сэргээлтийн бодлогын хүрээнд "Эгийн голын Усан цахилгаан станц" барих ажлын ТЭЗҮ, зураг төсвийг хийлгэхээр Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яаманд уламжлан хамтран, дэмжин ажиллах саналыг хүргүүлээд байна.	70
3.2.5	Үндэсний хэмжээний мега төслүүдийг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.	8,600.0	8,600.0	Хэрэгжиж буй төслийн тоо хэмжээ	2020	-	2021	1	Европын Холбооны SWITCH Asia-II хөтөлбөрийн санхүүжилттэй Каритас Чех Репаблик байгууллагын "Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төслөлтэй хамтран хог ангилан ялгах хошигн саваыг үр ашигтайгаар хэрэглэх дадлыг эзэмшүүлэх санг сурталчилгааны ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж байна. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг Азийн хөгжлийн банкны 8.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Заг инженеринг" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулаад байна.	90

**ДӨРӨВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ. Дэд бүтцийг хүн ам, хэрэглэгчдийн болон эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.**

**Зорилт 4.1. Хот байгуулалт, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, орон сууцны шинэ хороолол байгуулж, иргэдийн аюулгүй, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх**

4.1.1	Аймгийн газар зохион байгуулалтыг хөгжлийн хэтийн зорилт, хот төлөвлөлттэй уялдуулан зохион байгуулж, газар олголын үйл ажиллагаа, ашиглалтын байдал ил тод болсон байна.	500.0	500.0	Ажлын гүйцэтгэлээр	2020	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах гэрээ байгуулагдсан.	2022	Аймгийн ГЗБЕТ-ын төсөл 90 хувьтай хийгдсэн. 7 сумын ИТХ-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна.	Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу "Вектор мэн" ХХК 2019-2021 оны хооронд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын IX Хуралдаанд хэлэлцүүлж, 2022 оны IX/18 дугаар тогтоолоор баталгаажуулан газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах ажлыг гүйцэтгэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 7 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
-------	---	-------	-------	--------------------	------	--	------	--	--	-----

4.1.2	Сумдад нэгдсэн халаалт, халуун хүйтэн ус, бохирын шугам сүлжээг шинээр барин, өргөтгөх ажлыг үргэлжлүүлж, аймгийн төвийн хэрэглэгчдийг хэрэглээний халуун устай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна.	1,400.0	1,400.0	Ажлын гүйцэтгэлээр	2021	57182м шугамтай	2022	Тухайн онд төлөвлөсөн дэд бүтцийн шугам сүлжээг гүйцэтгэсэн байна.	Булган сумын 4 дүгээр ус, дулаан дамжуулах төвөөс "Далгарх өргөө" нийтийн орон сууц, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлыг "Марвель хаус констракш" ХХК гүйцэтгэж, холбогдох туршилт, тохируулгыг хийж, улсын комисс 2022 оны 06 дугаар сард хүлээн авсан. Сэлэнгэ сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжийн системийн угсралтын ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр "Долоон бар" ХХК 2021-2022 онд гүйцэтгэж, 2022 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулан үйл ажиллагаа хэвийн явж байна. Баян-Агт суманд орон нутгийн төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 970 м, Ф200 мм-ийн ариутгах татуургын шугам сүлжээ, 35 м.куб/онгоор хүчин чадалтай сефтик цэвэрлэх байгууламжийн ажил хийгдэхээр зураг төслийн ажлыг "Их мянган инженерчлэл" ХХК боловсруулсан. Гүйцэтгэгчээр "Эрин гүрэн" ХХК шалгаран 2021 оны 09 дүгээр сарын 01-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн ба он дамнан хэрэгжиж 2022 оны 08 дугаар сард ашиглалтад орсон. Орон нутгийн төсвийн 300.0 сая төгрөгөөр Сайхан сумын төвийн цэвэр усны төвлөрсөн системийн 3 дугаар шатны ажлыг "Тэнгэр хишиг" ХХК гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвийн 2 шатны 700.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Булган сумын 2 болон 5 дугаар УДДТ-ийн хамаарлын хэрэглэгчдийг хэрэгцээний халуун усны шугамд 18-ын А,Б, 22, 23, 14, 15, 12 байрны айл өрхүүд болон 1, 6 дугаар цэцэрлэгүүдийг гадна шугам холболтыг хийж ашиглалтад оруулаад байна. Инженерийн дэд бүтцийн энэ онд хийгдсэн шугамын урт Дулаан 274м, Бохир 907м, Цэвэр ус 1430м, хэрэглээний халуун ус 174м урттай байна.	100	
4.1.3	Орон нутгийн түүхий эд, байгалийн баялагт тулгуурласан барилгын материалын үйлдвэр, туршилт, сорилын лаборатори байгуулж, хөгжүүлсэн байна.	-	-	Байгуулагдсан барилгын материалын үйлдвэр, лаборатори	2020	Барилгын материалын туршилт сорилын лабораторийн байрлал	2022	Зураг төсвийг хийлгэсэн байна.	Барилгын материалын үйлдвэр, туршилт, сорилын лабораторийн барилгын зураг төсөв хийгдсэн.	100	
4.1.4	Булган хотыг шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлж, оршин суугчдын сэтгэлд нийцсэн бүтээн байгуулалтыг дэмжиж, иргэдийн тохилох амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	748.0	748.0	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	2020	Хотын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах гэрээ байгуулагдсан.	2022	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн дагуу хийгдсэн байна.	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн ажил дуусаж, шат шатны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэгдэн аймгийн ИТХ-ын 2022.03.29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор батлуулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Тус яамны сайдын зөвлөл болон гагдлалын хурлаар хэлэлцүүлэн хот төлөвлөлтийн нэгдсэн системд оруулан төлөвлөгөөг мөрдөн ажиллаж байна.	100	
4.1.5	Сумын төв болон шинэ суурьшлын бүсүүдийн эрчим хүч, мэдээлэл холбооны асуудал шат дараатайгаар шийдвэрлэгдэж, хангамж муутай, доголдолтой газруудад шинэчлэл хийгдсэн байв.	750.0	694.8	Эрчим хүч болон харилцаа холбооны сүлжээгээр хангагдсан сум, суурин, цэгийн тоо	-	-	2022	10-аас доошгүй байршилд үүрэн холбооны сүлжээтэй болсон байна. 1-ээс доошгүй суманд эрчим хүчний шинэчлэл хийсэн байна.	Бугат сумын Ханжаргалант багт улсын төсвийн 310 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "ЖЕМНИ" ХХК, Хутаг-Өндөр сумын Дондогын булагт улсын төсвийн 384.8 сая төгрөгийн санхүүжилтээр "Виртуал софт" ХХК тус тус ажлыг гүйцэтгэж 2022 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулсан. 2022 онд Юнител компани Бугат, Бургахангай, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Төшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын 14 багийг шинээр сүлжээнд холбосон. Мөн Булган сумын 6Д хороолол болон 3 дугаар баг, "Жаргалант" зуслан гэсэн 3 газарт шинээр цамхаг босгож, сүлжээний өргөтгөл хийв. Мобиком компани Орхон сумын Халиун багт, Сайхан сумын Угалз, Ундрах гэх 3 багт шинээр сүлжээний цамхаг босгон ашиглалтад оруулснаар энэ онд нийт 20 байршил үүрэн холбооны сүлжээнд холбогдлоо.	100	

**Зорилт 4.2. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашгийг, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын чанар, хүртээмжийг сайжруулах**

4.2.1	Авто замын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, улсын чанартай хатуу хучилттай авто замыг 98.9 км-ээр, орон нутгийн чанартай авто замыг 68.0 км-ээр уртасгаж, зарим суманд холимог хийцийн гүүр барьж, авто зогсоолын талбайн хүчин чадал 2000 м2-аар нэмэгдсэн байна.	14,745.0	2,425.8	Улсын чанартай авто замын гүйцэтгэлээр, аймгийн авто зогсоол нэмэгдсэн хэмжээгээр	2020	Булган-Орхон чиглэлийн хатуу хучилттай 34.8 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон.	2022	Орхон-Хишиг-Өндөр чиглэлийн 31.08 км хатуу хучилттай авто замын ажлыг үргэлжлүүлж, авто зогсоолын хэмжээг 800 м2-аар нэмэгдүүлсэн байна.	Булган сумын 5 дугаар баг "Өнө мандал" дэлгүүрийн урд талд 865 м.кв бетон авто зогсоолын талбай, явган хүний зам тавих ажлыг 75.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн улсын комисс хүлээн авсан. Улсын чанартай авто зам болох Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто замын ажлын үргэлжлэлийн хөрөнгө оруулалт болох 31.08 км авто замын төсвийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 1270.8 сая төгрөг тусгаж, ажлын гүйцэтгэгчээр "РЭС" ХХК шалгарч зам тээврийн хөгжлийн төвтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан энэ оны авто замын төлөвлөгөөт ажлыг гүйцэтгээд байна. "Дашинчилэн сумын 1.8 км авто замын төсвийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгаж, замын ажлын гүйцэтгэгчээр "Оффрөуд таван богд" ХХК шалгарч, зам тээврийн хөгжлийн төвтэй 1.49 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, энэ онд тавигдсан 800.0 сая төгрөгөөр замын ажлын эхлүүлсэн ба гүйцэтгэл 20.0 хувьтай байна. Аймгийн авто замын сангийн 280.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бугат сумын төвд 2.2 км, Орхон сумын төвд 2.8 км хатуу хучилттай авто замын ажлыг тус тус гүйцэтгэхээр "Булган АЗ3А" ТӨХК шалгаран ажлыг гүйцэтгэж байна. "Хялганат тосгоны төвийн 10 км авто замын гүйцэтгэгчээр "Увт инвест" ХХК ажиллаж байгаа бөгөөд замын ажил дуусах, явган замын хавтан суулах, гэрэлтүүлгийн ажил хийгдэж байна. Аймгийн Засаг даргын 2022.09.19-ний өдрийн 01/1046 тоот албан бичгээр Эрдэнэт хотоос Хангал сумын төв хүртэлх орон нутгийн чанартай 30 км авто замын ажлын гүйцэтгэгч "Замын битум" ХХК ББЭЗ-63-13/2022 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл, Хангал сумын төвөөс Хялганат тосгоны төмөр бетон гүүр хүртэлх 23.6 км авто замын ажил гүйцэтгэгч "Хурдны зам" ХХК-д ББЭЗ-63-05 дугаартай зөвшөөрөл, Хангал сумаас Хялганат тосгон хүртэлх авто замын дундаас Эрдэнэт үйлдвэрийн "Сэлэнгэ" амралтын бааз, Олимпын тамирчдын бэлтгэлийн бааз буюу 1-р подем чиглэлийн 10.4 км авто замын ажлын гүйцэтгэгч "Жавхланта харгуй" ХХК-д 2022.09.27-ны өдөр ББЭЗ-63-16/2022 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон. Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлын зардлыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, 2 дугаар багцын ажил буюу Хангал сумын төвөөс Хялганат тосгоны гүүр хүртэлх 23.6 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр "Хурдны зам" ХХК шалгарч энэ онд хийгдэх төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгээд байна.	90	
4.2.2	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, Булган суманд нийтийн тээврийн болон сурагчдын автобусны үйлчилгээ тогтмолжсон байна.	-	-	Хийгдсэн реисийн тоо	2021	-	2022	480 удаа дотоод реис хийсэн байна.	Хот тохижилт үйлчилгээний ангийн харьяалалд байдаг нийтийн тээврийн автобус Зүүн түрүүнээс 6 дугаар баг, шинэ хороо чиглэлд тогтмол үйлчилж байна. Хичээл сургуулийн үеэр өдөрт 2 удаагийн рейсийг хийж байна.	100	
4.2.3	Ерөнхий зориулалтын нислэгт зориулж, сонгогдсон сумдад нисэх буудлын талбай байгуулж, бага оврын агаарын хөлөг хөөрч, буух нөхцөл бүрдэн, аймгийн төв Улаанбаатар чиглэлд бага оврын агаарын хөлгийн нислэгийг бий болсон байна.	-	-	Сумдын нисэх буудлын талбайн тоо Нислэгийн тоо	2021	7 удаагийн туршилтын нислэг хийсэн.	2022	Тогтмол нислэг үйлддэг болсон байна.	"Монголын иргэний агаарын тээвэр" ТӨХК-д удаа дараа албан бичгээр санал хүсэлт хүргүүлсний хариуд 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 01/1388 тоот албан тоотгоор бага оврын агаарын хөлөгөөр Улаанбаатар-Булган-Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэх боломжгүй ба шалтгаан нь өнөөдрийн байдлаар "МИАТ" ТӨХК нь зөвхөн олон улсын агаарын шугаманд тогтмол болон захиалгат нислэг үйлдэж байгаа бөгөөд орон нутгийн нисэх буудалд буух бага оврын агаарын хөлөг байхгүй гэсэн хариуг ирүүлсэн. Цаашид "МИАТ" ТӨХК нь орон нутгийн нислэгийг олон улсын нислэгтэй холбох зорилгоор хувийн хэвшлийн агаарын тээвэр компаниудтай хамтарч ажиллахаар ярилцаж судлаж байна гэх албан бичгийг ирүүлээд байна. Хувийн хэвшлийн жижиг оврын ГЕО САН агаарын нислэгийн компани нь Булган аймгийн Баатарван амралтын газартай захиалгат нислэг үйлдэн ажиллаж байна.	30	

**ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО. Захиргааны оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий төрийн албыг төлөвшүүлж, цахим технологид тулгуурласан иргэн төсвийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ.**

**Зорилт 5.1. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохицтой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгох**



5.1.1	Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдэж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн байна.	250.0	312.4	Төрийн цахимжсан үйлчилгээг нэмэгдүүлэн өсгөсөн хувиар	-	-	2022	Төрийн үйлчилгээг цахимаар авагсдын тоог нэмэгдүүлж, E-Mongolia нэгдсэн төвтэй болсон байна. Тон гарын үсгийг нэвтрүүлнэ.	Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу аймгийн хэмжээнд 500 гаруй төрийн албан хаагч, 1842 иргэн, 16 сумын 325 аж ахуйн нэгж, байгууллагад тоон гарын үсэг олгосноор төрийн 800 гаруй үйлчилгээг тоон гарын үсэг ашиглан авах боломжтой боллоо. E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системийг 16 суманд бүрэн нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх "SMART BULGAN" гар утасны аппликацийн хэрэглээнд нэвтрүүлж, уг аппликацийн үйлчилгээнд тус газрын 18 төрийн үйлчилгээ, ЗДТГ-ын үйл ажиллагаа, төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг иргэдэд түгээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах боломжтой боллоо. Нийгмийн даатгалын үйлчилгээнд тус газрын 18 төрийн үйлчилгээ, Ehalamj.mn системээр 40 төрийн үйлчилгээг тус тус цахимжуулсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Г блокийг "E-Mongolia" төрийн үйлчилгээний нэгдсэн төв болгохоор 247.6 сая төгрөгөөр засвар үйлчилгээг хийж, 64.8 сая төгрөгийн техник хэрэгслээр хангасан. Тус төвийг 2022 оны 9 дүгээр сард нээж, төрийн үйлчилгээг иргэдэд дараалалгүй, түргэн шуурхай, цахимаар авах боломж бүрдсэн.	100
5.1.2	Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой нөхцөл бүрдсэн байна.	-	-	Хамтын ажиллагаатай ТББ-ын тоо	2020	9 төрийн бус байгууллагаатай хамтран ажиллаж байна.	2022	14 төрийн бус байгууллагаатай хамтын ажиллагаа сайжирсан байна.	Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд 14 төрийн бус байгууллагаатай хамтран 36 ажил, арга хэмжээг зохион байгуулав. Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаар аймгийн Засаг даргын 2022 оны А/68 дугаар захирамжаар удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилон үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн 11 дүгээр сард төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал сургалтыг зохион байгуулж, 23 агентлаг, 2 сумаас 60 төрийн албан хаагч эмэгтэйг хамруулав. Захиргааны чим хэмжээний актыг боловсруулахдаа хуулинд заасны дагуу иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 32 удаагийн хэлэлцүүлэг, 7 удаагийн нийтийн сонгогч зохион байгуулж, давхардсан тоогоор 6200 иргэний оролцуулав.	100
5.1.3	Нийгэм, эдийн засгийн үр дүнтэй гадаад харилцаа хөгжсөн байна.	-	-	Гадаад харилцаа холбоо, хамтын ажиллагааны арга хэмжээний тоо	2020	4	2022	10	БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /KOICA/-тай 3-5 жилийн хугацаанд Булган аймагт аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, тохижилт үйлчилгээг сайжруулах, бага дунд орлоготой өрхүүдийг дэмжих, сургалт явуулах, хөдөө аж ахуйн болон гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд олонгоос технологийг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхэллээ. Булган аймаг БНСУ-ын Кенги аймагтай хамтын ажиллагааны, Баяннуур сум БНСУ-ын Сөүл хотын Кангбүг дүүрэгтэй найрамдалт харилцааны, аймгийн Нэгдсэн эмнэлэг Солонгос улсын СОН-Э эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг тус тус байгуулав. АНУ-ын Элчин сайдын яам болон Монгол дахь Америк төсөгчдийн холбооны төлөөлөл, "Education USA Mongolia" хөтөлбөрийн зөвлөх баг манай аймагт ажиллаж, хөтөлбөрийн үйл ажиллагааны танилцуулга, тэтгэлэг хөтөлбөрийн мэдээлэл хийж, ЕБС-ийн 30 гаруй сургалтын менежер, англи хэлний багш нарт заах арга үйл сургалт орон нь аймгийн англи хэлний багш, сургагчдын мэдлэг, үр чадварыг хөгжүүлэхэд сайн үр дүн авчирлаа. АНУ-аас хамтын ажиллагааны хүрээнд англи хэлний мэргэжилтэн багш ажиллахаар ирсэнхэр аймгийн хэлний багш нарыг чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна сургагчид, төрийн албан хаагчдад зориулсан зорилтот сургалтуудыг үнэ төлбөргүйгээр явуулж эхэлсэн. Тус улсын Иргэн цэргийн дэмжлэгийн бүлэг ОБЕГ-тай хамтран Булган аймагт "Өндөрөөс аврах ажиллагаа"-ны 14 оногийн дадлага сургуулийг зохион байгуулсан. Бүгд Найрамдах Беларусь улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд тэргүүтэй төлөөлөгчид Булган аймагт, аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Беларусь улсад албан ёсны айлчлал хийж хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар манай аймгийн 3 оюутан Беларусь улсын Жодино хотын Политехникийн коллежид "Юнайтед белаэ машинери" ХХК-ийн 100 хувийн тэтгэлгээр суралцаж эхэллээ. Аймгийн ИТХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид Унгар, Чех улсад албан айлчлал хийж, айлчлалын хүрээнд Булган сум Унгар улсын Эгер хоттой хамтын ажиллагаатай хот болж, ажлын байр нэмэгдүүлж, дадлагажигч бэлтгэх урьдчилсан хэлэлцээрийг хийв. Төлөөлөгчид Чех улсын "Фенип" корпорацийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай танилцаж, Булган аймагт иргэдийн орлого, эдийн засагт тохирсон үнэ бүхий өвөр стандартын орон сууцныг Булган суманд барих асуудлыг шийдэж, Чех улсын "Контехин" группын үүсгэн байгуулагч тэргүүтэй төлөөлөгчид Булган аймагт айлчилж, барилгын ханын дулаалгын үйлдвэр, шар айрагны үйлдвэр барих асуудлаар албан уулзалт хийж, санал солилцон барилгын дулаалгын материал хийхэд шаардагдах түүхий эдийн дээжгийг авч, судалгааны ажил хийгдэж эхэллээ.	100
<b>Зорилт 5.2.</b> Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх										
5.2.1	Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба төлөвшсөн байна.	-	-	Төрийн албан хаагчдын ёс зүй дээшлүүлэх сургалт, арга хэмжээний тоо	2020	-	2022	Ёс зүйтэй төрийн албан хаагч жилийн аяныг хэрэгжүүлсэн байна.	2022 оны А/125 дугаар захирамжаар батлагдан "ЕС ЗҮЙТЭЙ, МЭДЛЭГ ЧАДВАРТА ХАРИУЦЛАГАТАЙ-ТӨРИЙН АЛБА"-ны жилийн аяныг 4 зорилтын хүрээнд 24 ажил үйлчилгээг зохион байгуулан 95.2 хувьтай хэрэгжилтийг тооцон ажиллалаа. "Төрийн алба хаагчийн нэгдсэн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж 17 сум, 47 агентлагын 300 гаруй төрийн албан хаагч нарт Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн "Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн үндэсний зөвлөх зэрэг газруудаас 8 илтгэгч мэдээллэл хийсэн. Мөн 16 сум болон төрийн байгууллага бүр "Төрийн албан хаагчийн зөвлөгөөн хэлэлцүүлгийг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж 1800 гаруй албан хаагчдыг хамруулсан. Төрийн захиргааны албан хаагчдын өдөр"-ийг тохиолдуулан сум, байгууллага бүр албан хаагчдын ёс зүйн үйл ажиллагааны талаар иргэдээс санал авч, санал асуулгын мөрөөр сайжруулах ажлуудыг зохион байгуулав. Боловсролын салбарын байгууллагын ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүдийн мэргэжилтэн арга зүйг дээшлүүлэх, чадваржуулах сургалтыг зохион байгуулж, Булган аймгийн сургууль, цацарлаг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн ёс зүйн зөвлөлийн 105 гишүүд хамрагдсан. Сургалтаар холбогдох хууль дүрэм, журам, салбарын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, хүхэд хамаалгын бодлого, хүхэдийн эсрэг гэмт хэрэг, эрүүл мэндийн боловсрол, эерэг харилцаа зэрэг сургалтууд хийж, кейс дээр дадлага ажлууд ажилласнаар, ёс зүйн зөрчилд дүнэлт гаргах, шийдвэрлэх үр чадвар сайжирсан.	100
5.2.2	Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг оновчтой болж, ажил үүргийн давхцал арилан шинэчлэл хийгдсэн байна.	-	-	Шинэчлэн батлагдсан албан тушаалын тодорхойлолтын тоо	2020	Төрийн албаны хуулийн хүрээнд төрийн захиргааны 109 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан.	2022	Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд төрийн захиргааны 109 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан байна.	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түнний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо шинэчлэгдэн батлагдан, төрийн захиргааны шинээр батлуулах албан тушаалын тодорхойлолтыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, хянан Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн батлах зөвшөөрөл авч, баталгаажуулалтад хяналт тавин ажиллаж байна. Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд чиг үүргийн давхцсан 35 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 20 агентлаг, 16 сум, 1 тосгоны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын дарга, Захирагчийн алба нийт 53 байгууллагын 324 төрийн захиргааны албан хаагчийн томилоонд хяналт шалгалт тавьж ажиллалаа. Төрийн захиргааны албан тушаалд 89 иргэний түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байсныг тусгай шалгалтын дүнгээр 71 иргэнийг нэр дэвшүүлэн томилох үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.	100
5.2.3	Төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоо боловсронгуй болсон байна.	-	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайн жилийн хувь	2020	54 албан хаагч нийгмийн баталгааны хөтөлбөрт хамрагдсан байна.	2022	110 төрийн албан хаагч нийгмийн баталгааны хөтөлбөрт хамрагдсан байна.	Төрийн албаны хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж, хүний нөөцийн хэрэгцээ, боловсон хүчинд тавигдах шаардлага өсөн нэмэгдэж байгаа тул төрийн албаны удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох, хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах, нийгмийн баталгааг хангах зорилгоор "Төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх аймгийн хөтөлбөр" боловсруулан аймгийн ИТХ-ын хурлаар батлуулсан. 114 төрийн албан хаагч нийгмийн баталгааны хөтөлбөрт хамрагдан 100 хувийн хэрэгжилттэй ажиллалаа.	100

5.2.4	Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдсэн байна.	-	-	Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо	2020	250 төрийн албан хаагч сургалтад хамрагдсан.	2022	2000-аас дээш төрийн албан хаагчийг чадавхижуулах сургалтад хамруулсан байна.	Удирдлагын академис 7 удаагийн сургалтыг онлайн сургалтыг авч давхардсан тоогоор сум байгууллагын 2450 гаруй албан хаагчид хамрагдаад байна. Удирдлагын академийн богино хугацааны сургалтад 37, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 18, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 22, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 14, эрхэлсэн түшмэлийн сургалтад 2 албан хаагч суралцаж байна. 2022 онд 8 байгууллагын 8 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн хүрээнд шилжүүлэн ажиллуулсан байна. 2022 онд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 6 багц сэдвийн 24 удаагийн "4-7-10" арга зүйн цахим сургалтад 154 байгууллагын 3600 албан хаагч оролцлоо. Салбар зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн дотоод чадавхижуулах сургалтад давхардсан тоогоор 25 байгууллагын 920 албан хаагч оролцсон. Мэргэжлийн бусад байгууллагын сургалтад 2500 гаруй албан хаагч хамрагдсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Цогц чадамжийг хэрэгжүүлэх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвүүдээр 12 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж, 58 байгууллагын давхардсан тоогоор 2000 гаруй албан хаагчийг хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлээ.	100
5.2.5	Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэж, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшсөн байна.	-	-	Стандарт шаардлагад нийцсэн төрийн байгууллагуудын тоо	-	-	2022	ISO9001 чанарын менежментийн тогтолцоог байгууллагуудад нэвтрүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Онцгой байдлын газар зэрэг төрийн байгууллагууд олон улсын ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж "Тэрчилгээ" авсан бол Бүрэгхангай, Булган сумын ЗДТГазар зэрэг төрийн байгууллагууд Чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.	100
5.2.6	Орон нутагт томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн асуудал сайжирсан байна.	2,213.0	2,692.0	Нийгмийн баталгааны хэрэгжилтийн хувь	-	-	2022	Төрийн албан хаагчдын нийгмийн асуудал үе шаттайгаар сайжирсан байна.	Төрийн байгууллага бүр Төрийн албаны тухай хуулийн 55.3 дугаар зүйлийн 55.1 дэх заалтыг үндэсэн төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулан, санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, гачигдал тохиолдсон үед тусламж үзүүлэх, орон сууцны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Албан томилолтын зардалд 111,505.5 мянган төгрөг, гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор ажиллахаар томилогдсон албан хаагчид тээврийн хэрэгсэл, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст тээврийн хэрэгсэл, ачаа тээшийн зардалд 100,2 мянган төгрөг, төрийн албан хаагч үүргээ гүйцэтгэж байхад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохирооноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүнийг авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан нийт хугацаанд нөхөн олгоход 206.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зөвшөөрлийг шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцахад 2000,0.0 мянган төгрөг, бусад нөхөх төлбөрт 78,997.35.0 мянган төгрөг, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэсэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж 840,835.75 мянган төгрөг, орон байраар хангагдах төрөөс дэмжлэг үзүүлэхэд 28,6500.0 мянган төгрөг, төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авахад зориулж 4,226.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Шүүхийн шинжилгээний албаны албан хаагчид орон нутагт томилолтоор ирэн ажиллахад зориулан байрлуулах 2 өрөө байрыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэн ажиллалаа.	90

**ЗУРГАА. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ. Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.**

**Зорилт 6.1. Батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг хангах, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх**

6.1.1	Батлан хамгаалах хууль тогтоомж, үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн бие бүрэлдэхүүний алба хаах, ажиллах нөхцөл сайжирсан байна.	12.0	0.0	Хууль тогтоомжийн болон нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлтийн хувь	2020	2004 онд баталсан Дайчилгааны төлөвлөгөөтэй.	2022	Батлан хамгаалах хууль тогтоомж, үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, 234 дүгээр ангид шинээр эмнэлгийн байр барьсан байна.	2200 гаруй иргэнд батлан хамгаалах чиглэлээр төрийн үйлчилгээ үзүүлээ. Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн нэр бүхий 101 иргэнд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах журмын холбогдох заалтын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар 92,469,000 сая төгрөгийн мөнгөн төлбөрийг ноогдуулж, мөнгөн төлбөрийг барагдуулах ажлыг шуурхай зохион байгуулан 100 хувь барагдуулсан байна. 2022 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг халах, татах ажлыг зохион байгуулж, 16 сум, 1 тосгоны 600 гаруй залуучуудыг эмчийн үзлэгт хамруулж, тэнцсэн иргэдийг Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн ангиудад хуваарилсан. Зэвсэгт Хүчний Жанжин штабаас ирүүлсэн хугацаат цэргийн алба хаагчдын хяналтын тоог 85 хувь биелүүлсэн. Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу Зэвсэгт хүчний 234 дүгээр ангид шинээр эмнэлэг барих хөрөнгийг шийдвэрлэх боломжгүй байна. 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 07-ны хооронд цэргийн үүрэгтийн тоо бүртгэлийг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд цэргийн бүртгэл 95,3%-тай явагдлаа. Цэргийн штабын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл" шатны сургалтыг 09 дүгээр сарын 10-24-ний өдрүүдэд Зэвсэг хүчний 234 дүгээр ангийн байрлалд зохион байгууллаа. Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйл 28.1.2 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын Булган аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай явуулах "Цэргийн бэлтгэл" сургалтыг 08 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд БХЯ, ЗХЖШ-тай хамтран зохион явуулсан. Сургалтад Архангай, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Орхон, Дархан, Сэлэнгэ аймгуудын сумдын ЗДТГ-ын 90 Тамгын газрын дарга, Цэргийн штабын 14 дарга, офицер, БХЯ, ЗХЖШ-ын 6 төлөөлөл нийт 110 бие бүрэлдэхүүн цэргийн бэлтгэл сургалтад хамрагдаж сургалтыг амжилттай зохион байгуулсан. 6 сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нартай 2022 оны 1 дүгээр сард 3 хоногийн хугацаатай Батлан хамгаалах хууль тогтоомжууд болон "Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, жагсаалтын эмхтгэл" Монгол Улсын "Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам" сургалт зохион байгуулан хүн нэг бүрээр нууцын баталгаа авсан.	70
6.1.2	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу тайван цагт орон нутгийн хамгаалалтын бэлтгэл хангагдаж, бие бүрэлдэхүүний сургалт, дадлагыг зохион байгуулж, орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдсэн байна.	9.0	9.0	Зохион байгуулсан сургалт, дадлагын тоо	2020	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг баталсан.	2022	16 сум, 1 тосгонд сургалт, дадлага зохион байгуулагдсан байна.	Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай явуулах "Цэргийн бэлтгэл" сургалтын яар орон нутгийн хамгаалалтын томилоот бүрэлдэхүүнтэй явуулах сургалтыг явуулсан бөгөөд 16 сум, 1 тосгоны "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-нд тодотгол хийж чөлөөт нөөцийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээс шинээр томилоогдуулсан.	90
6.1.3	Аймгийн дайчилгааны төлөвлөгөө шинэчлэгдэн, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын чанар сайжирч, цэргийн бэлтгэл үүргэний сургалтын төв байгуулагдсан байна.	10.0	-	Дайчилгаа болон сургалтын тоо	2020	2020 онд нэгдүгээр зэргийн 40 бэлтгэл үүрэгтэнийг сургалтад хамруулсан.	2022	Бэлтгэл бэлэн байдал сайжирсан байна.	ЗХЖШ-ын даргын маш нууц удирдамжийн дагуу аймгийн "Зэвсэгт хүчний анги, салбарыг хүн техникээр нөхөн хангах төлөвлөгөө"-г боловсруулан ЗХЖШ-ын даргаар батлуулсан тус төлөвлөгөөний дайчилгааны даалгаврын дагуу аймгийн Засаг даргын А/514 дүгээр захирамж гаргаж 16 сум, 1 тосгоны дайчилгааны төлөвлөгөөг ажлын хэсэг гарган боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан сумдын Засаг дарга нар т хуульчид өгсөн. Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2022 оны А/413 дугаар захирамжийн дагуу цэргийн 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 20 иргэнийг Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 6 дугаар сарын 27-ноос 07 дугаар сарын 07-ны хооронд цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг зохион байгуулан явууллаа. АЗДТГ-ын 5 давхарт Цэргийн штабын сургалтын танхим байгуулж цэргийн бэлтгэл сургалтуудыг явуулах боломж бүрдсэн.	100

6.1.4	Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, эх орон тусгаар тогтнолоороо бахархан тээгч болгосон байна.	2.0	2.0	Таниулах сургалт, арга хэмжээ зохион байгуулсан тоо	2020	2020 онд хүүхэд залуучдыг эх оронч үзлээр төлөвшүүлэх 3 арга хэмжээг зохион байгуулсан.	2022	Цэргийн штабын сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлын хүрээнд 3-аас багагүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газартай хамтран Монгол улсын баатар хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан Булган сумын ЕБ-ын 3 сургууль, 2 МСҮТ-ийн сургалтад "Залуу жанжин Ж.Лхагвасүрэн", "Булган аймгаас төрөн гарсан цэргийн адартангууд"-ын талаарх мэдээллийг хүргэж, сурталчилан, цэрэг спортын "Дөл" тоглолтыг зохион байгуулсан. Тэмцээнд 7 сумын баг тамирчид оролцлоо. Тэрг үүн байрт шалгарсан тасаг БХЯ-ны Сайдын нэрэмжит "Дөл-2022" улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан. 2022 оны 08 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2022" цогцолбор тэмцээнд Булган аймгаас оролцсон баг тамирчид амжилттай оролцсон. Монгол хурандаа нийгэмлэг, анхны хурандаа З.Жанцан сантай хамтран Монголын анхны хурандаа Зүндийн Жанцангийн хөшөөг Булган сумын сансар цэцэрлэг хүрээлэнд нундэтгэлтэйгээр байрлуулсан. Уг арга хэмжээнд сумын иргэд төрөл төрөгсөд болон бусад албаны хүмүүс оролцлоо. Монгол цэргийн нэгдсэн холбоо төрийн бус байгууллага болон "Отгонтэнгэр" их сургуулиас хамтран улсын хэмжээнд зохион байгуулсан "Монгол улсын хөгжил дэвшилд миний оруулах хувь нэмэр" эсээ бичлэгийн уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 300 гаруй эсээ бичлэгээс Булган сумын 3 дугаар сургуулийн 2 сургалч, 4, 6 дугаар байр эзэлж, "Отгонтэнгэр" их сургуульд 1 дүгээр курст үнэ төлбөргүй суралцах эрхийн бичгээр шагнагдсан байна.	100
<b>Зорилт 6.2. Хууль сахиулах салбарын бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх</b>										
6.2.1	Хууль сахиулах салбарын хүний нөөцийн чадавх, ажиллах орчин, материаллаг бааз бэхжигдсэн байна.	60.0	60.0	Хөрөнгө оруулалтын хэмжээ	2020	Байгууллагуудын автомашины эдлэгний хугацаа дууссан.	2022	Хүний нөөцийн чадавх, ажиллах орчин, материаллаг бааз бэхжигдсэн байна.	2022 онд салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор автомашиныг шинэчлэхэд орон нутгаас 110,000,000 төгрөгийг шийдвэрлэн худалдан авалт хийгдсэн байна.	100
6.2.2	Иргэдэд эрх зүйн боловсрол олгох чиглэлээр "Бүх нийтийн эрх зүйн боловсрол дэд хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	15.0	15.0	Бүх нийтийн эрх зүйн боловсрол дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2020	89.2	2022	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.	2022 онд "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийн хүрээнд төрийн 74 байгууллагын 2984 алба хаагч, 4579 иргэн, ЕБС-ийн 5754 сурагчдад танхимын хэлбэрээр холбогдох хууль эрх зүйн мэдээллээр сургалт зохион байгуулсан байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 224 эрх зүйн хөтөч ажиллаж байна. Эрх зүйн хөтөч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан. 16 сум, 1 тосгоны албан ёсны Эрх зүйн хөтөч цахим /facebook/ хуудсаар дамжуулан 241 төрлийн хууль, эрх зүйн мэдээллийг байршуулан давхардсан тоогоор 2571 иргэн үзсэн байна. Эрх зүйн хөтөч нарын шинээр мөрдөгдөж буй хуулиудаар бэлтгэсэн 1500 ширхэг гарын авлага, хууль хяналтын байгууллагуудын эрх зүйн 1089 ширхэг зөвлөмж, материалыг 2589 малчдад хүргэн ажилласан. Бүх нийтийн боловсрол олгох хөтөлбөрийн хэрэгжилт 96.6 хувьтай гүйцэтгэлээ.	100
6.2.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр иргэдийн оролцоо хангагдсан байна.	12.0	36.0	Олон нийтийн цагдаагийн тоо, иргэдийн тоо	2020	Аймгийн хэмжээнд 8 олон нийтийн цагдаа ажилласан.	2022	Аймгийн хэмжээнд 9 олон нийтийн цагдаа ажиллуула.	2022 оны 4 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 1, 2022 оны 09 дүгээр сарын 10-наас 11 дүгээр сарын 10-ны хооронд ой, хэзэрийн гүймэр гарч болзошгүй 8 суманд 20 хүний бүрэлдэхүүнтэй морин эргүүл ажиллуулах зорилгоор аймгийн Засаг даргын А/207 дугаар захирамж гаргасан. Морин эргүүл, идэвхтэн байгаж хамгаалагчийн урамшуулалд орон нутгийн төсвөөс 29,988,000 төгрөгийг сумдад шилжүүлсэн. Булган сумын хэмжээнд "Хөрсийн ханалт"-ын бүлгийг шинэчлэн байгуулан бүлгийн бүрэлдэхүүнийг 4 хүнтэй 6 баг байгуулан гэр бүлийн хүчирхийллийн эрсдэл бүхий айл өрхийн судалгааг шинэчлэн гаргаж тайлан хугацаанд давхардсан тоогоор судалгаанд 6 багийн 120 иргэн ажиллаж байна. Сотгуураг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор архинаас гаргах сэтгэл заслын минесота загварын эмчилгээний хөтөлбөрт 18 иргэн гэр бүлийн хамт хамрагдаж, эмчилгээ, сургалт нийт 20 хоног үргэлжилсэн. Төслийн үйл ажиллагаанд Булган аймагт үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг Булган сумын "Дэвшил АА" бүлэг, Бугат сумын "Тэгээрэл АА" бүлэг, Орхон аймгийн "Халуун сэтгэл АА" бүлгүүд хамтран ажилласан. 2022 онд аймгийн хэмжээнд 14 олон нийтийн цагдаа ажиллаж байна. Олон нийтийн цагдаа ажиллуулж байгаа сумдаас хөдөлмөр хөлсний доод хэмжээ 420,000 төгрөгөөр цалинжуулж байна. 2022 онд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 1151 иргэн, 5 төрийн бус байгууллагын оролцоогоор ханган ажилласан байна.	100
6.2.4	Гэмт хэргэтай тэмцэх, нийтийн хэв журам сахиулах шууд чиг үүрэг бүхий Цагдаагийн газар болон криминалистик, шүүх эмнэлэг болон тусгай шинжилгээний хүчин чадал бэхжиж, ашиглах тоног төхөөрөмж шинэчлэгдэн сайжирсан байна.	60.0	110.0	Хөрөнгө оруулалтын хэмжээ	2020	Байгууллагуудын автомашины эдлэгний хугацаа дууссан.	2022	2 байгууллагад парк шинэчлэлт хийсэн байна	Аймгийн Шүүх шинжилгээний албанд томилогдон ажиллаж байгаа криминалистикийн шинжээч болон шинжээч эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад зориулж аймгийн ЗДТГ-аас 60 сая төгрөгийг өртөг бүхий 2 өрөө байр тэндэр зарлан худалдан авсан. Орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Цагдаагийн газарт БНСУ-д үйлдвэрлэсэн N.County маркын 22 хүний суудалтай бага оврын автобусыг нийлүүлсэн.	100
6.2.5	Төрийн болон албаны нууц задарч, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаал, төрийн болон албаны нууцтай холбоотой гэмт хэрэг, зөрчилгүй ажилласан байна.	-	-	Гэмт хэрэг, зөрчлийн тоо	2020	Гэмт хэрэг, зөрчил гараагүй.	2022	Гэмт хэрэг, зөрчил гараагүй байна.	2022 онд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2 дугаар улиралд 16 сум 1 тосгоны нууц хариуцдаг алба хаагчдын төрийн болон албаны нууц хадгалалтад хяналт шалгалт хийж ажилласан. Шалгалтын үеэр алба хаагчид нууцтай холбоотой баримтуудыг тусгай сөйфөнд хадгалж байна. Онцгой нөхцөл байдлын үед төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын төлөвлөгөө боловсруулан ажиллах талаар зөвлөсөн. 2022 онд авлига, албан тушаал, төрийн болон албаны нууцтай холбоотой гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй байна.	90
6.2.6	Төрийн санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөл сайжирч, үе шаттай цахим хэлбэрт шилжсэн байна.	58.8	58.8	Баримт бичгийн хадгалалт сайжирч, цахимд шилжилт нэмэгдсэн тоо	2021	Нийт байнга 21371 х/н Үүнээс 4682 х/н. Хувь 21.9	2022	Нийт байнга 21371 х/н Үүнээс 4803 х/н Хувь 22.4-д хүргэсэн байна.	Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд архивын зориулалтын байртай болох зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/348 дугаар захирамжаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Урагч бэлэн болсон. 2022 оны 12 дугаар сарын байдлаар лавлагаа авах хүсэлт гаргасан 780 иргэнд 3416 баримтаар үйлчилсэн. Үүнээс тушаалын 1940 баримт, цалингийн 1393 баримт, малын А дансны 36 баримт, нотариатын 47 баримт гарган үйлчилсэн. Мөн Архивын 8 хөмрөгийн 8 дансны 121 хадгаламжийн нэгжийн 8649 хуудас баримтыг скайнердан мастер буюу анхны хувийг үйлдэн тусгай файл үүсгэн хадгалж ажлыг зохион байгуулав. Архивын баримтыг 8 хөмрөгийн 8 дансны 121 хадгаламжийн нэгжийн нийт 8649 хуудас баримтыг фото шоп программаар засварлан ашиглалтын хувийг үйлдэн тусгай файл үүсгэн хадгалсан.	100
<b>ДОЛОО. БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарыг бус нутгийн түвшинд тогтвортой хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</b>										
<b>Зорилт 7.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлэх</b>										
7.1.1	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зорилгот зах зээл, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, тээвэр, борлуулалтын ложистикийн сүлжээг байгуулж, эдийн засгийн үр өгөөж сайжирна.	-	-	Эдийн засгийн өсөлтийн хувь	-	-	2022	Хөвсгөл, Орхон, Дархан-Уул аймгуудтай бизнес хамтын ажиллагааг өргөжүүлж, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлсэн байна.	Булган, Орхон аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чөлөөт худалдаа хийгдэж байна. Худалдааны дундын бус байгууллахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан. Мөн Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөж, сурталчлах зорилгоор "Өвлийн идэш", "Цагаан сар", "Алтан намар", Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэгч, малчид, иргэдийг зохион байгуулан оролцууллаа.	100
7.1.2	Мал, амьтны өвчний гаралт, тархалт буурч, бус нутгийн түвшинд халдварт өвчнөөр тайван байдал баталгаажна.	-	-	Мал, амьтны өвчлөл буурсан хувийр	2020	Нийт өвчлөлийн 2 хувь	2022	1.98 хувь хүртэл буурна.	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн 607.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1.4 сая мал амьтан хамруулахаар төлөвлөсөнөөс 1.39 сая мал амьтан, Шимгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 4.0 сая мал амьтан хамруулахаар төлөвлөсөнөөс 3.1 сая мал амьтан, улсын төсвийн 296.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шулхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 362.0 мянган толгой мал хамруулахаас 343.9 мянган толгой мал, Бруцеллээ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 773.4 мянган толгой мал хамруулахаас 744.7 мянган толгой мал, амьтан хамруулснаар өвчний гаралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар буураад байна.	100

7.1.3	Булган, Бүрэгхангай суманд малын тэжээлийн үйлдвэр байгуулж, түүхий эдийн нөөцөөр хангагдсан байна.	-	-	Байгуулагдсан малын тэжээлийн үйлдвэрийн тоо	2020	Төшиг, Хутаг-Өндөр, Орхон суманд тус бүр 1 малын тэжээлийн үйлдвэр байна.	2022	Булган, Бүрэгхангай суманд малын тэжээлийн үйлдвэр байгуулна.	"Дархан хаан Молор" ХХК малын тэжээлийн үйлдвэр байгуулж, 98 га талбайд тариалалт хийж, 48 тн тэжээл хураан авлаа.	50	
7.1.4	Хутаг-Өндөр, Булган суманд тус бүр 500 тн-ын багтаамжтай механикжсан зоорь барьж, төмс, хүнсний ногооны борлуулалтын тогтвортой байдал хангагдана.	-	-	Баригдсан механикжсан зоорийн тоо	2020	200 тн багтаамжтай механикжсан зоорьтой.	2022	Зураг, төсвийг хийлгэнэ.	Бүгд Найрамдах Польш Улсын санхүүжилтээр хэрэгжиж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" төсөлд хамрагдахаар Булган суманд 1000 тоннны багтаамжтай механикжсан зоорь барих зураг төсөв, газрын асуудлыг шийдвэрлэж, холбогдох материалыг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.	100	
7.1.5	Баяннуур сумын "Бор булан"-гийн хадлангийн талбайг хашиж хамгаалан, бэлтгэсэн өвс тэжээлийг урд бүсийн сумдад нийлүүлнэ.	300.0	300.0	Далан сэргээн засварлагдаж хадлан хадах боломж бүрдсэн байна.	-	-	2022	Хадлангийн талбайн хамгаалалтын даланг сэргээн засварлана.	Баяннуур сумын Бор булангийн хадлангийн талбайг засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бөндөр 2 удаа зарлагдаж, 2022 оны 12 дугаар сарын 19-нд нээнэ. Сонгон шалгаруулах ажил Төрийн худалдан авах ажиллагааны газарт хийгдэж байна.	30	
7.1.6	Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилан, Рашаант, Гурванбулаг, Сайхан, Хишиг-Өндөр, Могод сумдын нутагт улийн цагаан оготнотой тэмцэх ажлыг ээлж дараатайгаар жил бүр хийж, бэлчээрийг хамгаалах арга хэмжээг авсан байна.	64.0	64.0	Тэмцлийн ажил хийгдсэн талбайн хэмжээ	2020	147.5 мянган га талбайд ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн.	2022	40.0 мянган га-аас доошгүй талбайд хэрэгжүүлнэ.	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 64.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баяннуур, Гурванбулаг, Дашинчилан, Рашаант, Сайхан сумын 40.0 мянган га бэлчээрийн талбайд хөнөөлт мэрэгч амьтадтай тэмцэх ажлыг энгийн механик, микробиологийн аргаар зохион байгуулсан.	100	
7.1.7	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн төвийг хөгжүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	-	-	Булган үйлдвэр технологийн паркийг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортолын хэмжээ	2020	УТП-ын ТЭЗУ боловсруулагдсан.	2022	Мах боловсруулах үйлдвэр бүтээн байгуулах судалгааны ажлыг гүйцэтгэж, үйлдвэр технологийн парк инженерийн дэд бүтцийн зураг төсвийг боловсруулах хөрөнгийг шийдвэрлэнэ.	Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөнд манай аймагт махны агро парк байгуулахаар тусгагдаж, Булган сумын 4 дүгээр баг Домын дэвсгэт 91302 м.кв талбай бүхий газрыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 15 жилийн хугацаатай газар эзэмшүүлэх шийдвэрийг гарган цахимаар газрын гэрээ байгуулан гэрчилгээжүүлж, БНХАУ-ын 19.5 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор" баригдах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.	50	Махны үйлдвэр байгуулах ажил хойшлогдсон.
7.1.8	Булган, Орхон суманд бетон зуурмагийн үйлдвэр байгуулж, барилга үйлдвэрлэлийн өртгийг зохистой түвшинд барина.	-	-	Байгуулагдсан үйлдвэрийн тоо	2020	Аймгийн хэмжээнд бетон зуурмагийн үйлдвэр байхгүй.	2022	Булган суманд Бетон зуурмагийн үйлдвэр байгуулсан байна.	Булган сумын 1-р баг Байгаль орчин-4 гудамж 410 тоот байршилтай газарт "Дэвших конкрет" ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр ашиглалтад орж, 540 гаруй тн зуурмаг орон нутгийн барилга бүтээн байгуулалтад нийлүүлсэн байна. Цементийн хомсдол, үнийн өсөлтөөс шалтгаалж бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байна. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Булган сумын Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөмж өгч ажиллаа.	100	
7.1.9	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, уул уурхайн болон аж ахуйн томоохон байгууллагуудын захиалгат ажлыг орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлж, тэдний орлогыг нэмэгдүүлнэ.	-	-	Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо	2020	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т хамтран ажиллах санал хүргүүлсэн.	2022	Гэрээ байгуулж, аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдсэн байна.	Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах, түншлэлд оролцоог байх заалтын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газарт бүтээгдэхүүн нийлүүлэх бололцоо бүхий аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн судалгааг хүргүүлсэн. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилчдыг гэрээгээр амраадаг амралт, аялал жуулчлалын 11 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээ олгосноор орон нутгийн аж ахуйн нэгжүүд тус үйлдвэртэй гэрээгээ үргэлжлүүлэн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Булган аймгийн Засаг дарга, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газар, Бүрэгхангай сумын уурхайнудтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд Булган аймагт үйлдвэрлэсэн чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүний үйлдвэрийн хэрэгцээнд нийлүүлэхээр тусгаж, орон нутгийн үйлдвэрийн бүтээгдэхүүний стандартын шаардлагад нийцүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж байна. Уул уурхай эрхлэгчидтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, хүнсний гол нарийн бүтээгдэхүүн болох мах, сүү, цагаан идээ, хүнсний ногоо зэргийг орон нутгаас нийлүүлэх талаар 14 аж ахуйн нэгжтэй зөвшилцөлд хүрч 3 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, 640.0 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.	70	
7.1.10	Авто зам, замын байгууламжийг өргөтгөж, Гурванбулаг-Хишиг-Өндөр-Орхон-Булган чиглэлийн 133.7 км, Орхон аймаг-Хялганат чиглэлийн 53 км авто замыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулсан байна.	12,000.0	3,270.8	Авто замын барилгын ажлын км-ын хэмжээ	2020	34.8 км	2022	31.08 км	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 99.7 км хатуу хүчилтлэй авто замын ажлын үргэлжлэлийн хөрөнгө оруулалт болох 31.08 км авто замын төсвийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 1270.8 сая төгрөг тусгаж, ажлын гүйцэтгэгчээр "РЭС" ХХК шалгарч Зам тээврийн хөгжлийн төвтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан энэ оны авто замын төлөвлөгөөт ажлыг гүйцэтгээд байна. Аймгийн Засаг даргын 2022.09.19-ний өдрийн 01/1046 тоот албан бичгээр Эрдэнэт хотоос Хангал сумын төв хүртэлх 30 км авто замын чанартай 30 км авто замын ажлын гүйцэтгэгч "Замын битум" ХХК ББЭЗ-63-13/2022 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл, Хангал сумын төвөөс Хялганат тосгоны төмөр бетон гүүр хүртэлх 23.6 км авто замын ажил гүйцэтгэгч "Хурдны зам" ХХК-д ББЭЗ-63-05 дугаартай зөвшөөрөл, Хангал сумаас Хялганат тосгон хүртэлх авто замын дундаас Эрдэнэт үйлдвэрийн "Сэлэнгэ" амралтын бааз, Олимпын тамирчдын бэлтгэлийн бааз буюу 1-р подем чиглэлийн 10.4 км авто замын ажлын гүйцэтгэгч "Жавхлантай харгуй" ХХК-д 2022.09.27-ны өдөр ББЭЗ-63-16/2022 дугаартай ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон. Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хүчилтлэй авто замын ажлын зардлыг "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, 2 дугаар багцын ажил буюу Хангал сумын төвөөс Хялганат тосгоны гүүр хүртэлх 23.6 км хатуу хүчилтлэй авто замын гүйцэтгэгчээр "Хурдны зам" ХХК шалгарч энэ онд хийгдэх төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгээд байна.	70	
7.1.11	Сайхан сумын Эрээний нүүрсний уурхайн үйл ажиллагаа тогтворжиж, орон нутаг төдийгүй хөрш зэргэлдээ зарим аймаг, сумдын нүүрсний хэрэгцээг хангана.	500.0	-	Борлуулалтад гаргасан сайжруулсан түлшний хэмжээ	2020	Булган сумын шахмал түлшний үйлдвэр жилд 40-50 тн түлш нийлүүлж байна. Сэлэнгэ сум, Хялганат тосгонд үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд суурилагдсан.	2022	Сайжруулсан түлшний үйлдвэрийн барилга, усралтын ажлыг эхлүүлнэ.	Сайхан сумын Эрээний нүүрсний ордыг түшиглэж, орон нутгийн төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар жилд 10000 тоннны хүчин чадалтай сайжруулсан түлшний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл бэлэн болсны дараа үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	30	
<b>Зорилт 7.2.</b> Бүс нутгийн байгалийн баялаг, өвөрмөц тогтоц, газарзүйн байршил, түүх соёлын дурсгал зэрэг жуулчдын татах байдалд тулгуурлан аялал жуулчлалыг бүсчилэн хөгжүүлж, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх											
7.2.1	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулснаар өрсөлдөх чадвар дээшилж, жуулчдын тоо 2 дахин нэмэгдэнэ.	100.0	224.0	Гадаад жуулчдын тоо	2019	7000	2022	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулах зорилгоор форум зохион байгуулна. Булганыг зорин ирсэн жуулчдын тоо 50000-аас илүү байна.	Энэ онд аймгийн хэмжээнд 5 эвент арга хэмжээг төлөвлөн "Хангинахын шугуйн шагайн тойром"-ын арга хэмжээг 5 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Орхон аймагтай хамтарч, 7 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд "RFC MONGOLIA BULGANKHANGAI 2022" олон улсын бартаат замын уралдаан, 8 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд "АЙПАГ НААДАМ" арга хэмжээ, 10 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд "Aragday" арга хэмжээ, 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд "ITM Mongolia 2022" арга хэмжээг тус тус зохион байгуулаа. Эдгээр эвент арга хэмжээг зохион байгуулахад 224.0 сая төгрөгийг зарцуулан ажиллаж, гадаадын 8500, дотоодын 100000 орчим аялагчид эвент арга хэмжээнийг үзэж сонирхохоор зорин ирсэн байна.	100	

7.2.2	Баян-Агт, Сайхан, Могод, Хутаг-Өндөр сумын нутгийг хамарсан эрүүл мэнд, рашаан сувиллын аялал жуулчлалыг байгалийн үзэсгэлэнт тогтоц, адуун соёл, айраг брэндтэй хослуулан нутгийн иргэдийн оролцоотой хөгжүүлсэн байна.	-	-	Оролцогчдын тоо	2020	15000	2022	Төлөвлөгөөний дагуу 5 ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэсэн байна.	Аймгийн аялал жуулчлалын веб сайтыг аж ахуйн нэгжийн мэдээлэл, зорин ирсэн жуулчдын тоо, үйлчилгээний байгууллагын хүчин чадлыг байршуулсан дата бүрдүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 1316 хүн хүлээн авах чадалтай 18 жуулчны бааз, 371 хүн хүлээн авах хүчин чадалтай 19 зочид буудал, 4537 хүн хүлээн авах хүчин чадалтай 141 амралтын газар, 245 ортой 5 сувилал, 40 ортой 3 ангийн отог, 120 ортой 31 гэр кемп үйл ажиллагаа явуулж байна.	100	
7.2.3	Түүх, археологийн үнэт дурсгалт газрууд болон Хөгнө-Тарнын байгалийн цогцолбор газарт түр буудаллах цэг байгуулагдаж, орон нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлал хөгжсөн байна.	200.0	200.0	Түр буудаллах цэг баригдсан тоо	2020	2019 онд Рашаант суманд "Хаан бууз" ХХК-ийн түр буудаллах цэг байгуулагдсан.	2022	Рашаант, Баян-Агт сумдад түр буудаллах цэг байгуулна.	Улсын төсвийн хөрөнгөөр Рашаант суманд "Өвөлжөөн булаг" ХХК, Баян-Агт суманд "Цонхот" ХХК-иуд отоглох цэг барих ажлын гүйцэтгэгчээр шалгарч Отоглох цэгийн ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэн ашиглаж байгууллага болох Баян-Агт сумын ЗДТГ, Рашаант сумын Хөгнө тарны байгалийн цогцолбот газрын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өглөө.	100	
7.2.4	Эг-Сэлэнгэ, Эг-Тарвагатайн бэлчир, Зэд-Хантай бүтээлийн нурууны дархан цаазат газарт спорт загасчлал, усан аялал зэрэг тусгай сонирхлын адал явдалт аялал хөгжинө.	-	-	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	2020	Зураг төсөв хийгдсэн.	2022	Аялал жуулчлалын жуулчлалын мастер төлөвлөгөөний 1-р үе шатны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангана.	Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа аялагчдад зориулан маршрут гарган отоглох цэгүүдийг тохижуулаад байна.	50	
		<b>63,569.9</b>	<b>35,956.1</b>					<b>ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</b>		<b>89.7</b>	

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**